

ЗАВХАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

**ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН АШИГЛАЛТ, ХАМГААЛАЛТАД ТАВИХ
ХЯНАЛТ ОРХИГДСОН БАЙНА**

“АЙМГИЙН ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧИЙН ХАРЬЯА
БАЙГУУЛЛАГУУДЫН ҮНДСЭН ХӨРӨНГИЙН АШИГЛАЛТ, ХАМГААЛАЛТ” СЭДЭВТ
АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН КОД: ЗАА-2025/41-ШТА-ГА



Завхан аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
Төргүүлэх аудитор Д.Бат-Ундраа
Утас: 704623612 цахим хуудас: bat-undraad@audit.gov.mn
Аудитын менежер Х.Болдбаатар
Утас: 70463783 цахим хуудас: boldbaatarakh@audit.gov.mn
Ахлах аудитор Б.Жалбаа
Утас: 89330330, Цахим хаяг: jalbaab@audit.gov.mn
Аудитор Д.Пүүжмаа
Утас: 99080797, Цахим хаяг: puujmaad@audit.gov.mn
Аудитор Л.Гансүлд
Утас: 88161818, Цахим хаяг: gansuldl@audit.gov.mn

Улиастай хот 2025 он

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу. Цахим хуудас: www.audit.mn

АГУУЛГА

ТУШААЛ	3
ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР.....	4
ХҮСНЭГТИЙН ТОВЬЁГ.....	5

АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ, СТАНДАРТ, АРГА ЗҮЙН ТАЛААРХ МЭДЭГДЭЛ	6
--	---

ЗОРИЛТ 1. ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГУУДЫН ХӨРӨНГИЙН ХЭРЭГЦЭЭ, ШААРДЛАГЫН ТАЛААРХ СУДАЛГАА ХИЙГЭЭГҮЙ БАЙНА.

7-16

- 1.1 Орон нутгийн өмчийн талаарх эрх зүйн орчин бүрдсэн ч сайжруулах шаардлагатай байна.
- 1.2 Орон нутгийн өмчид хөрөнгө олж бэлтгэх талаарх эрх зүйн орчин болох журмын заалтыг хүчингүй болгосон байна.
- 1.3 Төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа байгууллагуудад хэрэгцээтэй болон илүүдэлтэй хөрөнгийн судалгаа гаргаагүй байна.
- 1.4 Хөрөнгийн шинж чанартай зүйлсийг бараа материал дансанд бүртгэх хандлага тогтсон байна.

ЗОРИЛТ 2. ХӨРӨНГИЙГ БОГИНО ХУГАЦААНД ЭЛЭГДҮҮЛЭН, ДАНС БҮРТГЭЛЭЭС ХАСДАГ НИЙТЛЭГ ЗӨРЧИЛ БИЙ БОЛСОН БАЙНА.

16-26

- 2.1 Үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацааг бодитой тодорхойлоогүй байна.
- 2.2 Цаашид ашиглах боломжтой хөрөнгийг дахин үнэлж эхэлсэн байна.
- 2.3 Хандив тусламж, хөрөнгө оруулалтын хүрээнд бий болсон хөрөнгийг хэнд эзэмшүүлэх, хэрхэн ашиглах нь тодорхой бус байна.
- 2.4 Эд хөрөнгийн ашиглалтын картын хөтлөлт хангалтгүй, хөдөлгөөн гарсан тухай бүр шинэчлэн хөтлөөгүй байна.
- 2.5 Орон нутгийн өмчийг акталж данс бүртгэлээс хасах, балансаас шилжүүлэх, дуудлага худалдаагаар худалдан борлуулах үйл явц хяналтгүй, урсгалаар явагдаж байна.
- 2.6 Орон нутгийн өмчийг бусдад үнэ төлбөргүй өгдөг жишиг тогтох хандлагатай болсон байна.
- 2.7 Эд хөрөнгийг худалдан борлуулах дуудлага худалдааг хууль журмын зохион байгуулсан эсэхэд дүгнэлт өгөх боломжгүй байна.
- 2.8 Орон нутгийн өмчийг бусдад ашиглуулсны /түрээсийн/ төлбөрийг төсөвт бүрэн төвлөрүүлээгүй байна.

2.9 Эд хөрөнгө худалдан борлуулсны орлогыг төсөвт бүрэн төвлөрүүлээгүй байна.

2.10 Төрийн сан дахь орон нутгийн өмчийн орлогын данснаас шууд зарцуулалт хийсэн байна.

ЗОРИЛТ 3. ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН АШИГЛАЛТ, ХАМГААЛАЛТАД ТАВИХ ХЯНАЛТ ХАНГАЛТГҮЙ БАЙНА.

26-30

3.1 Эрх бүхий байгууллагаас гарсан шийдвэрийн хэрэгжилт хяналтгүй байна.

3.2 Эрх бүхий байгууллагуудаас эд хөрөнгийн ашиглалтад, хамгаалалтад хяналт хийгээгүй байна.

3.3 Орон нутгийн өмчтэй холбоотой нэгдсэн тооллого зохин байгуулж, биелэлтийг тооцон ажиллаагүй байна.

3.4 Төрийн өмчийг эзэмших гэрээг бодитой дүгнэж, хэрэгжилт хангалтгүй төсөв захирагч нарт хариуцлага тооцоогүй байна.

3.5 Өмч хамгаалах зөвлөлийн үйл ажиллагаа хангалтгүй байна.

ДҮГНЭЛТ.....	31
ЗӨВЛӨМЖ:.....	32
ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ.....	33
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ТАЙЛБАР.....	34

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
ҮАГ	Үндэсний Аудитын Газар
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан

ХҮСНЭГТИЙН ТОВЬЁГ

№	Тайлбар	Хуудасны дугаар
1	Үндсэн хөрөнгийн орлого	
2	Төсвийн хөрөнгөөр худалдан авсан хөрөнгө	
3	Үндсэн хөрөнгийн үлдэгдэл	
4	Тээврийн хэрэгслийн тоо	
5	Бараа материалын үлдэгдэл	
6	Хандив тусламж, хөрөнгө оруулалтаар нийлүүлэгдсэн хөрөнгө	
7	Үндсэн хөрөнгө данс бүртгэлээс хасахтай холбоотой шийдвэр	
8	Дуудлага худалдаагаар худалдах хөрөнгийн тоо	
9	Түрээсийн орлого	
10	Төрийн сан дахь орон нутгийн өмчийн орлого	
11	Аймгийн ИТХ-аас гаргасан шийдвэр	

ГРАФИК ДҮРСЛЭЛИЙН ТОВЬЁГ

№	Тайлбар	Хуудасны дугаар
1	Үндсэн хөрөнгийн нийт үлдэгдэл	
2	Үндсэн хөрөнгийн эзлэх хувь	
3	Хөрөнгө оруулалт хөрөнгийн нэр төрлөөр	

СУДАЛГААНЫ ТОВЬЁГ

№	Тайлбар	Хуудасны дугаар
1	Төсвийн хөрөнгөөр худалдан авсан хөрөнгийн товчоо	
2	Ашиглалтад хүлээн авсан мөчөөс ажиллаагүй хөрөнгө	
3	Дансанд бүртгэлтэй илүүдэлтэй болон ашиглалтгүй хөрөнгө	
4	Авто тээврийн төвд бүртгэлтэй тээврийн хэрэгслийн тоо	
5	Зөв ангилж бүртгээгүй хөрөнгийн жагсаалт	
6	Урсгал засварын шинжтэй хөрөнгө, бараа материалын судалгаа	
7	Элэгдэл тооцох хугацааг бүртгээгүй хөрөнгийн жагсаалт	
8	Элэгдэл тооцох хугацааг бодитой тогтоогоогүй хөрөнгийн судалгаа	
9	Байгууллагын дансанд бүртгэлгүй хөрөнгө	
10	Шийдвэрийг буруу гаргасан хөрөнгө	
11	Аудитын тооллогоор дутсан хөрөнгө	
12	Түрээсийн орлого	
13	Дуудлага худалдааны орлого	
14	Эд хөрөнгөтэй холбоотой шийдвэрийн хэрэгжилт	

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх	Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт арга зүй Аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төрийн аудитын байгууллагын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгасны дагуу хийж гүйцэтгэсэн.
Аудитын зорилт	Аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа байгууллагуудын хөрөнгийн ашиглалт, хамгаалалтын байдалд дүгнэлт өгч, зөвлөмж боловсруулан, дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж, иргэд олон нийтэд мэдээлэхэд чиглэгдсэн. Уг зорилгыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэлээ. Үүнд: • <i>Орон нутгийн өмчид хөрөнгө бэлтгэхдээ хэрэгцээ шаардлагад үндэслэсэн эсэх;</i> • <i>Орон нутгийн өмчийг зориулалтын дагуу ашиглаж, хууль журамд нийцүүлэн данс бүртгэлээс хассан эсэх;</i> • <i>Орон нутгийн өмчийн ашиглалтад, хамгаалалтад тавих хяналт хангалттай эсэх;</i>
Аудитын хамарсан хүрээ	Аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа төсөвт байгууллагууд, орон нутгийн өмчит аж ахуйн нэгжийг хамруулан, байгууллагын данс бүртгэлд тусгагдсан үндсэн хөрөнгө, бараа материалын ашиглалт, хамгаалалтын байдалд аудит хийсэн.
Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт	Аудитыг гүйцэтгэлийн аудитын стандарт АДБОУС 100, 300, 400, 3000-3100, 4000, Монгол Улсын Төрийн аудитын стандарт MNS 6817-5:2020 “Гүйцэтгэлийн аудитын зарчим”, MNS 6817-6:2020 “Нийцлийн аудитын зарчим”, MNS 6817-7:2020 “Гүйцэтгэлийн аудитын стандарт”, MNS 6817-8:2020 “Нийцлийн аудитын стандарт”, “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ын дагуу аудитын зорилго, зорилт, асуудлын шинжилгээний асуултад хариулт өгөхөд шаардагдах бүх төрлийн нотлох баримтыг цуглуулж, баримтжуулан, тэдгээрийг нягтлан шалгах, дүн шинжилгээ хийх, харьцуулах, тулган баталгаажуулах, түүвэрлэлт хийх зэрэг судалгааны арга зүйг ашигласан.
Аудитын багийн бүрэлдэхүүн, хугацаа Хүндрэл бэрхшээл	Аудитыг Завхан аймаг дахь Төрийн Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Д.Бат-Ундраа, аудитын менежер Х.Болдбаатар нар хянан удирдаж, ахлах аудитор Б.Жалбаа, аудитор Д.Пүүжмаа, Л.Гансүлд нар 2025 оны 07 дугаар сарын 05-аас эхлэн 2025 оны 12 дугаар сарын 15-ний хооронд хийж гүйцэтгэлээ. Аудитыг гүйцэтгэх хугацаанд холбогдох байгууллагуудын алба хаагчдын ээлжийн амралт таарч байсан нь биет тооллого хийхэд хүндрэлтэй байлаа. Мөн аудитын багийн нэг гишүүн аудитын явцад эрүүл мэндийн шалтгааны улмаас хагалгаанд орсон нь хүний нөөц дутагдаж, цаг хугацаандаа амжихгүй байх эрсдэлийг бий болсон.



ЗАВХАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОРЫН ТУШААЛ

2025 оны 12 сарын 04 өдөр

Дугаар А/41

Улиастай

Тайлан баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1, 20 дугаар зүйлийн 20.1, 20.4, 29 дүгээр зүйлийн 29.4 дэх хэсэг, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам"-ын 18.9, 18.10 дахь хэсэг, 2023 оны А/102 дугаар тушаалын дөрөвдүгээр хавсралтаар баталсан "Аймаг, нийслэл дэх Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторт шилжүүлэх эрх" -ийн 1.4 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1."Аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа байгууллагуудын үндсэн хөрөнгийн ашиглалт, хамгаалалт" сэдэвт гүйцэтгэлийн аудитын тайланг нэгдүгээр, төлбөрийн акт, албан шаардлагыг хоёрдугаар хавсралтаар баталгаажуулсугай.

2.Аудитаар өгсөн зөвлөмжийг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д заасны дагуу төлөвлөгөө гарган ирүүлж, хэрэгжүүлэх арга хэмжээ авч, биелэлтийг тогтоосон хугацаанд ирүүлэхийг холбогдох албан тушаалтнуудад зөвлөсүгэй.

3.Аудитын тайланг холбогдох байгууллага, албан тушаалтнуудад хүргүүлэхийг аудитор (Д.Пүүжмаа)-д, цахим хуудсаар нийтэд мэдээлэхийг аудитор (Г.Нармандах)-д үүрэг болгосугай.

4.Аудитын ажлын болон нотлох баримтыг 2025 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн дотор архивын нэгж болгон байгууллагын архивд хүлээлгэн өгөхийг аудитын баг (ахлах аудитор Б.Жалбаа)-д даалгасугай.

5.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аудитын менежер (Х.Болдбаатар)-т үүрэг болгосугай.



Д.БАТ-УНДРАА

D:\Албан бичиг\Тушаал-А-2025.docx

812501005

Аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа 64 байгууллага үйл ажиллагаа явуулж байна. Эдгээр байгууллагын данс бүртгэлд 2024 оны жилийн эцсийн байдлаар нийт 81,997.9 сая төгрөгийн үндсэн хөрөнгө бүртгэлтэй байв.

2024 онд төсвийн хөрөнгөөр 1,080.3 сая төгрөгийн хөрөнгө худалдан авч, 378.9 сая төгрөгийн хөрөнгө шилжүүлэн авсан, хөрөнгө оруулалт болон бусад хэлбэрээр 17,105.9 сая төгрөгийн хөрөнгийг бий болгож, 3,196.5 сая төгрөгийн хөрөнгийг данс бүртгэлээс хассан байна.

ЗОРИЛТ 1. ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГУУДЫН ӨМЧ ХӨРӨНГИЙН ХЭРЭГЦЭЭ, ШААРДЛАГЫН ТАЛААРХ СУДАЛГАА ХИЙГЭЭГҮЙ БАЙНА.

1.1 Орон нутгийн өмчийн талаарх эрх зүйн орчин бүрдсэн ч аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар баталсан журамд шинэчлэл хийх шаардлагатай байна.

Орон нутгийн өмчид хөрөнгө бэлтгэх, актлах, баланс хооронд шилжүүлэх, дуудлага худалдаа зохион байгуулах, өмчийн зүйлсийг бусдад түрээслүүлэх талаарх эрх зүйн орчин бүрдсэн байна.

Аймгийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн 2023 оны VIII хуралдааны тогтоолоор “Орон нутгийн өмчид хуулийн этгээдийн эд хөрөнгийн харилцааг зохицуулах журам”-ыг шинэчлэн батлахдаа холбогдох хуулийн заалтыг мөрдөөгүй дордуулсан журмын зүйл заалтууд оруулж, хоорондоо зөрчилдсөн байна гэж үзлээ.

Тухайлбал:

✓ Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн

6.1.3-д “эрх бүхий байгууллагын шийдвэрээр худалдан авсан эд хөрөнгө”, 75 дугаар зүйлийн 75.1-д “энэ хуулийн 6 дугаар зүйлийн 1-4, 6 дахь заалт, 6.2, 6.3 дахь хэсэгт заасан хэлбэрээр бий болсон эд хөрөнгө”, 77.2.3-д “орон нутгийн өмчийн үндсэн хөрөнгийг хувьчлах ба бусдад шилжүүлэх, шинээр олж авах жагсаалт, төлөвлөгөө, эх үүсвэрийг хэлэлцэж батлах” гэсэн байхад дээрх журмын 3.2, 3.4 дэх заалтуудыг хүчингүй болгосон. Гэтэл тухайн журмын 1.2-д эд хөрөнгө олж авахдаа ИТХ-д тавьж шийдвэрлүүлэх зохицуулалттай байна.

✓ Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын зарим зүйл заалтыг орхигдуулсан байна.

Үүнд: Дөрөвдүгээр бүлэгт төрийн өмчийн эд хөрөнгө бүртгэх талаар дэлгэрэнгүй тусгасан байна. Энэхүү бүлэгт заасан 4.1.2-дах заалтад үндэслэн төсвийн ерөнхийлөн захирагчийн дэргэдэх хөрөнгө оруулалтын хэлтэс, төрийн өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай хэрхэн ажиллах талаар, 4.3, 4.4, 4.5, 4.7, 4.8-дахь заалтууд, долоодугаар бүлэгт заасан хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох зохицуулалтыг, 8 дугаар бүлгийн 8.6 дахь заалтыг нэмж оруулах нь зүйтэй байна.

✓ Аймгийн ИТХ-ын тогтоолоор баталсан журмын 4.4 дахь хэсгийн Орон нутгийн өмчийн газарт асуудлаа тавьж шийдвэрлүүлнэ гэсэн хэсгийг өөрчлөн Орон нутгийн өмчийн газраар дамжуулан ИТХ-аар шийдвэрлүүлнэ гэж оруулбал илүү үр дүнтэй байна гэж үзлээ.

✓ Хөрөнгийн ашиглалтын /элэгдэл тооцох/ хугацааг хэрхэн тогтоох талаар мөрдөж буй эрх зүйн зохицуулалт хангалтгүй, нарийвчлан тодорхой тусгаагүйн улмаас төсөвт байгууллагууд өөр өөрийн үзэмжээр элэгдэл тооцох хугацааг оруулсан байна.

Иймд Аймгийн ИТХ-аар баталсан журамд хөрөнгийн ашиглалтын хугацааг хэрхэн тогтоох талаар тодорхой байдлаар тусгаж, хавсралтаар баталж өгөх нь зүйтэй байна.

✓ Газар болон үндсэн хөрөнгө, тээврийн хэрэгслийн гэрчилгээ олголт, цэнхэр дугаар авах, хөрөнгийн /тоног төхөөрөмж, машин механизм/ түрээсийн талаар тусгаж өгөөгүй байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа байгууллагууд нь Аймгийн ИТХ-аас гаргасан журмыг үйл ажиллагаандаа мөрдөн ажилладаг тул аль болох нарийвчилсан зохицуулалтуудыг оруулж өгөх шаардлагатай байна.

Журамд зөвхөн аудитаар өгсөн санал зөвлөмжөөр хязгаарлалгүй судалгаа, дүн шинжилгээ хийж нэмэлт өөрчлөлтүүдийг оруулах нь зүйтэй юм. Ингэхдээ байгууллагуудын төсөв захирагч, санхүүгийн алба хаагчдаас санал авч тусгавал илүү үр дүнд хүрнэ гэж үзлээ.

1.2 Орон нутгийн өмчид хөрөнгө олж бэлтгэх талаарх эрх зүйн орчин болох журмын заалтыг хүчингүй болгосон байна.

2020-2024 оны хооронд орон нутгийн өмч хөрөнгө нийт 44,979.63 сая төгрөгөөр нэмэгдсэнээс төсвийн хөрөнгөөр 3,828.04 сая төгрөгийн хөрөнгө бэлтгэсэн байна.

Хүснэгт 1. Үндсэн хөрөнгийн орлого /сая.төг/

д/д	Он	Мөнгөн дүн	Үүнээс				
			Худалдан авсан	Хандив /хөрөнгө оруулалт/	Шилжүүлэн авсан	Бусад	Дахин үнэлгээгээр нэмэгдсэн
1	2020	1,399.54	311.54	691.26	93.90	277.39	25.45
2	2021	2,940.08	425.06	1,898.54	368.63	207.48	40.37
3	2022	12,048.60	943.03	2,583.17	3,115.15	5,335.04	72.23
4	2023	10,026.36	1,068.15	2,949.95	745.21	5,144.91	118.15
5	2024	18,565.05	1,080.27	7,025.62	378.89	10,080.26	0
ДҮН		44,979.63	3,828.05	15,148.54	4,701.78	21,045.08	256.2

Эх сурвалж: ТЕЗ-ийн нэгтгэсэн тайлан

Орон нутгийн өмчид худалдан авсан хөрөнгийг нэр төрлөөр нь задлан харуулбал:

Хүснэгт 2. Орон нутгийн өмчид төсвийн хөрөнгөөр худалдан авсан хөрөнгө /сая.төг/

д/д	Он	Барилга байгууламж	Тээврийн хэрэгсэл	Машин тоног төхөөрөмж	Тавилга, эд хогшил	Ном	Бусад үндсэн хөрөнгө	Программ хангамж	Нийт дүн
1	2020	70.0		115.95	7.22	0.06	49.03	69.28	311.54
2	2021	113.29	27.35	217.33	23.14	0.39	43.28	0.28	425.06
3	2022	176.26	95.20	557.56	50.16	0.53	62.88	0.44	943.03
4	2023	364.22	212.44	240.56	23.92	0.27	195.24	31.5	1,068.15
5	2024	482.45	44.60	363.91	103.85	1.70	77.32	6.44	1,080.27
ДҮН		1,206.22	379.59	1,495.31	208.29	2.95	427.75	107.94	3,828.05

Эх сурвалж: ТЕЗ-ийн нэгтгэсэн тайлан

Барилга байгууламж нь аймгийн ТЕЗ-аас сумдын төсөв захирагч нарт эрх шилжүүлэн гүйцэтгүүлсэн хөрөнгө оруулалтын ажлуудтай холбоотой бөгөөд зөвхөн 2023 онд л үндсэн хөрөнгө бүртгэх зөвшөөрөл олгосон шийдвэр гаргасан байна.

Тавилга эд хогшил бэлтгэх шийдвэрийг тухайн сумын ИТХ, аймгийн засаг даргын дэргэдэх газар, хэлтсүүдийн хувьд Аймгийн ИТХ гаргаж байхаар аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн 2018 оны 25 тоот тогтоолоор зохицуулсан байдаг.

2020-2024 онд аймгийн засаг даргын дэргэдэх газар, хэлтэс, орон нутгийн өмчит аж ахуй нэгжүүд 47.8 сая төгрөгийн тавилга, эд хогшил бэлтгэсэн байхад эрх бүхий байгууллагаас ямар ч шийдвэр гараагүй байна.

Аймгийн ИТХ-аас 2020, 2021 онуудад ТЕЗ-ийн харьяа байгууллагуудтай холбоотой 79.28 сая төгрөгийн тоног төхөөрөмж бэлтгэх 10 шийдвэрийг гаргасан бөгөөд 2023 оноос хойш орон нутгийн өмчид хөрөнгө бэлтгэхтэй холбоотой шийдвэр гаргаагүй байна. Энэ нь Аймгийн ИТХ-ын хуралдаанаар төрийн өмчид эд хөрөнгө олж бэлтгэхэд аймгийн ИТХ-аас зөвшөөрөл авах зохицуулалтыг тухайн хурлын тогтоолоор баталсан журамд хүчингүй болгосонтой холбоотой байна.

Нэн ялангуяа тээврийн хэрэгсэл худалдан авахтай холбоотой асуудлыг аймгийн ИТХ-аар хэлэлцээгүй нь учир дутагдалтай байна.

/Судалгаа 1-д худалдан авалтыг байгууллага бүрээр харуулав/

Орон нутгийн өмчид хөрөнгө олж бэлтгэхтэй холбоотой асуудлыг аймгийн ИТХ-аар хэлэлцэхгүй байгаа нь дараах эрсдэлийг бий болгож байна гэж үзлээ.

- Төсвийн хөрөнгө үр ашиггүй, үрэлгэн зарцуулагдах
- Хөрөнгийн эх үүсвэр давхардаж, орон нутгийн өмчид хөрөнгийн илүүдэл үүсэж, хөрөнгө дутагдах, эзэнгүйдэх
- Ашиглалтгүй хөрөнгө бий болж, хөрөнгийн хамгаалалт алдагдах
- Эрх бүхий байгууллагаас тавих хяналт сулрах зэрэг байна.

Иймд хүчингүй болгосон заалтыг эргэн харж, журамд нэмж оруулах нь зүйтэй байна.

1.3 Төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа байгууллагуудад хэрэгцээтэй болон илүүдэлтэй хөрөнгийн судалгаа гаргаагүй байна.

ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧИЙН ХАРЬЯА БАЙГУУЛЛАГУУДЫН ХӨРӨНГИЙН АШИГЛАЛТ, ХАМГААЛАЛТ

ТЕЗ-ийн харьяа байгууллагуудын данс бүртгэлд 2024 оны жилийн эцсийн байдлаар 2,756.27 сая төгрөгийн бараа материал, 81,997.88 сая төгрөгийн үндсэн хөрөнгө бүртгэлтэй байна.

Үндсэн хөрөнгийн үлдэгдлийг өмнөх онуудтай харьцуулахад дараах байдалтай байна.

Хүснэгт 3. Үндсэн хөрөнгийн нийт үлдэгдэл /сая.төг/

Он	Нийт үлдэгдэл	Үүнээс							
		Барилга, байгууламж	Тээврийн хэрэгсэл	Тоног төхөөрөмж	Тавилга, эд хогшил	Ном	Бусад үндсэн хөрөнгө	Программ хангамж	Бусад биет бус хөрөнгө
2020	46,840.27	24,023.78	5,212.10	9,383.32	1,679.59	24.65	4,571.29	113.66	1,831.87
2021	47,386.82	24,120.99	5,478.66	9,415.62	1,667.52	24.85	4,734.39	114.11	1,830.67
2022	57,443.02	30,526.24	6,247.11	10,250.67	1,779.82	23.67	5,774.97	118.67	2,721.88
2023	66,629.36	33,557.88	7,995.88	12,307.20	1,795.92	28.66	7,771.63	175.04	2,997.15
2024	81,997.88	37,640.36	12,670.98	15,325.21	2,233.41	30.36	9,783.58	179.28	4,134.70
Зөрүү	35,157.61	13,616.58	7,458.88	5,941.89	553.82	5.71	5,212.29	65.62	2,302.83
Өсөлт %	42.88	36.18	58.87	38.77	24.79	18.81	53.28	36.60	55.69

Эх сурвалж: ТЕЗ-ийн нэгтгэсэн тайлан

График 1. Үндсэн хөрөнгийн нийт үлдэгдэл /сая.төг/




Үндсэн хөрөнгийн 2024 оны үлдэгдлийг 2020 онтой харьцуулахад 5 жилийн хугацаанд 35,157.61 сая төгрөгөөр буюу 42.9 орчим хувийн өсөлттэй байна.

ТЕЗ-ийн харьяа байгууллагуудад 2020-2024 онуудад орон нутгийн хөрөнгө оруулалтаар санхүүгийн программ, компьютер, мотоцикл зэрэг хөрөнгүүдийг нийлүүлсэн байна. Орон нутгийн хөрөнгө оруулалтаар нийлүүлэгдсэн тоног төхөөрөмжийн хүчин чадал, мотоциклийн техникийн үзүүлэлт, чанар хангалтгүй байгаа талаарх гомдол саналыг уулзалт ярилцлагын үеэр холбогдох албан хаагчид тэмдэглэн хэлж байлаа.

Харин санхүүгийн программын хувьд ашиглалт нэлээд хангалтгүй байсанд Төрийн аудитын газраас санхүүгийн тайлангийн аудитаар удаа дараа зөвлөмж, албан шаардлага өгч, хэрэгжилтийг хангуулан ажилласан.

График 2. Үндсэн хөрөнгийн эзлэх хувь



Орон нутгийн өмчийн өсөлт өндөр байгаа нь ашиглалтгүй хөрөнгө бий болох, хөрөнгө шамшигдах, үр ашиггүй зарцуулагдах, хөрөнгийн хамгаалалт алдагдах зэрэг эрсдэл бий болох нөхцөлийг бүрдүүлж байна гэж үзлээ.

Орон нутгийн өмчид олж бэлтгэсэн хөрөнгө /орлого/ болон 2024 оны байдлаарх хөрөнгийн үлдэгдэлд дүн шинжилгээ хийхэд дараах нөхцөл байдалтай байна.

Барилга байгууламж: Орон нутгийн болон орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар бий болсон хөрөнгүүдийн зарим хэсэг орон нутгийн хэрэгцээ шаардлагыг хангахгүй, чанаргүй, ашиглалтад хүлээн авсан мөчөөс одоог хүртэл ашиглалтгүй, газрын маргаантай, зарим хөрөнгүүд нь эвдэрч гэмтсэн байна. /Судалгаа 2-т харуулав/

Тэрчлэн төсөв захирагч нар хуучин халуун усны барилгын ашиглалтыг сайжруулах, засаж сэргээх ажлыг хийхгүй, тэдгээртэй адил хөрөнгийг дахин барьж, үхмэл хөрөнгүүдийг бий болгож байна.

Төрийн өмчит байгууллагуудын барилга байгууламжийн үлдэгдэлд дээрхээс гадна ашиглалтгүй барилга байгууламжууд бүртгэлтэй байна.

/Судалгаа 3-т харуулав/

Нэгэнт тухайн сум орон нутаг, байгууллага ашиглахгүй байгаа хөрөнгүүдийг үнэ цэнээ алдаж, эвдэрч гэмтэхээс өмнө худалдан борлуулах нь зүйтэй гэж үзлээ.



Мөн байгууллагын дансанд бүртгэлтэй газрыг барилга байгууламжтай тулгахад зөрүүтэй, зарим барилгын газрыг данс бүртгэлд тусгаагүй байна. Иймд аймгийн хэмжээнд нэгдсэн арга хэмжээг Газрын харилцаа барилга хот байгуулалтын газартай хамтран зохион байгуулж, төсөвт байгууллагуудын газрын асуудлыг цэгцлэх нь зүйтэй байна.

Тээврийн хэрэгсэл: ТЕЗ-ийн харьяа төсөвт байгууллагуудад 2024 оны байдлаар 512 тээврийн хэрэгсэл бүртгэлтэй байна.

Хүснэгт 4. Тээврийн хэрэгслийн тоо

д/д	Тээврийн хэрэгслийн төрөл	Байгууллагын эзэмшилд байгаа тоо
1	Мотоцикл	254
2	Суудлын машин	102
3	Трактор /бүх төрөл/	73
4	Бусад	83
	ДҮН	512

Эх сурвалж: Төсөвт байгууллагуудын үндсэн хөрөнгийн бүртгэл

Байгууллагуудын дансанд бүртгэлтэй тээврийн хэрэгслийн дүнд суудлын авто машин, мотоцикл зэрэг хөрөнгүүд ихэнх хувийг эзэлж байна.

- Мотоциклийг сумдын багийн дарга, мал эмнэлгийн тасгийн мэргэжилтэн, сумын цагдаа, байгаль орчны байцаагч нар ашиглаж байгаа бөгөөд зарим байгууллагын алба хаагчид 3 мотоцикл ногдож байна. Энэ нь тухайн алба хаагчид шинээр худалдан авсан хөрөнгийг өгөхдөө өмнө нь ашиглаж байсан хөрөнгийг хураан авсны дараа өгдөггүй, өмнөх хөрөнгийн ашиглалтын байдлыг харгалзан үздэггүй зэрэгтэй холбоотой байна.

Мөн орон нутгийн хөрөнгө оруулалтаар хөрөнгө бэлтгэхдээ албан тушаалын нэр зааж /багийн дарга нарт гэх мэт/ олгодог нь дээрх нөхцөл байдлыг бий болгож байна. Өөрөөр хэлбэл тухайн албан тушаалтан өөрт нь зориулан тухайн хөрөнгийг нийлүүлсэн тул өмнө нь ашиглаж байсан хөрөнгө эвдэрч гэмтсэнээс үл хамааран заавал авдаг /өгдөг/ тогтолцоо бий болсон байна.

Цаашид уг тогтолцоог халж, тухайн хөрөнгийг бусад алба хаагчдад шилжүүлэн өгвөл хөрөнгө оруулалтын зардал хэмнэгдэх боломж байна.

Орон нутгийн төсвийн 2024 оны хөрөнгө оруулалтаар мотоцикл нийлүүлэхдээ сумдын хөрөнгийн үлдэгдэлд дүн шинжилгээ хийж, хэрэгцээ шаардлагыг бодитой тодорхойлоогүйгээс хөрөнгийн давхардал бий болсон байна гэж үзлээ. Учир нь зарим сумд 2022, 2023 онуудад сумын багийн дарга нарт мотоцикл худалдан авч өгсөн байна.

Аудитаар хөрөнгийн эх үүсвэр давхардуулан худалдан авалт хийсэн 69.1 сая төгрөгийн 24 мотоцикл байна гэж үзлээ.

/Судалгаа 3-т байгууллагаар харуулав/

- Суудлын авто машиныг орон нутагт аймаг, сумын засаг дарга, аймгийн

ИТХ-ын дарга унах эрхтэй байна. ТЕЗ-ийн харьяа 64 байгууллагын 38 байгууллагад 102 суудлын авто машин байгаа нь тээврийн хэрэгслийн илүүдэл байгааг харуулж байна. Тухайлбал: Аймгийн ЗДТГ-ын хувьд 9, Их уул сумын ЗДТГ 6, бусад байгууллагад дунджаар 3 суудлын авто машинтай байна.

Бодит байдалд аймгийн ЗДТГ-т 5, сумдын нутгийн захиргааны байгууллагад 2, бусад төсөвт байгууллагуудад 1 суудлын тээврийн хэрэгсэл байхад төрийн үйлчилгээг иргэдэд хүргэхэд хүндрэл тулгарахааргүй байна гэж үзэн байгууллага бүрийн тээврийн хэрэгслийн үлдэгдэлд дүн шинжилгээ хийж 1,082.3 сая төгрөгийн 33 суудлын автомашиныг илүүдэлтэй байна гэж тооцлоо.

/Судалгаа 3-т байгууллагаар харуулав/

Хөрөнгө оруулалтаар нийлүүлэгдсэн тээврийн хэрэгслийг сумдад хуваарилахдаа давуу байдлаа ашиглаж буй тохиолдол аудитын явцад ажиглагдлаа. Их-уул сумын ЗДТГ нь бусад байгууллагуудтай харьцуулахад тээврийн хэрэгсэл хангалттай байхад 2025 онд хөрөнгө оруулалтаар нийлүүлэгдсэн тээврийн хэрэгслийг /хогны машин-2ш/ тус байгууллагад өгч байгаа нь учир дутагдалтай байна.

Ийнхүү хөрөнгө илүүдэлтэй байх нь төсвийн хөрөнгө үр ашиггүй зарцуулагдах /шатахуун/, хөрөнгийн ашиглалт хамгаалалт алдагдах /эвдрэх, тоногдох, дутагдах/ эрсдэлийг нэмэгдүүлж байна.

Жишээ нь: Аудитаар сумдад ажиллахад тухайн тээврийн хэрэгслийг хэн дуртай нь унадаг, хувийн хашаандаа өөрийн мэт эзэмшиж, ашигладаг, ээлжийн амралтаараа хувийн хэрэгцээндээ хэрэглэдэг зэрэг байдал ажиглагдлаа. Гэтэл засвар арчлалтын зардал төрөөс /төсвөөс/ гарч татвар төлөгчдийн мөнгийг үр ашиггүй үрэлгэн зарцуулж байна.

Иймд илүүдэлтэй тээврийн хэрэгслийн ашиглах боломжтой машин, мотоциклийг хөрөнгө дутагдалтай байгууллагад шилжүүлэх, үлдсэн илүүдэлтэй хөрөнгийг худалдан борлуулах нь зүйтэй гэж үзлээ.

Байгууллагын дансанд бүртгэлтэй тээврийн хэрэгслийг Авто тээврийн төвд бүртгэлтэй тээврийн хэрэгсэлтэй тулгахад байгууллагын бүртгэл зөрүүтэй байна.

/Судалгаа 4-д байгууллага бүрээр харуулав/

Байгууллагуудын дансанд бүртгэлтэй тээврийн хэрэгслийн гэрчилгээг тухайн байгууллагуудын нэр дээр шилжүүлдэггүй, худалдан авсан хувь иргэн, хуулийн этгээдийн нэр дээр бүртгэлтэй зөрчлүүд нийтлэг байна. Энэ нь тухайн хөрөнгө дутагдах, үрэгдэх гол хүчин зүйл болж байна. Иймд тухайн байгууллагын тээврийн хэрэгслийг цэнхэр дугаартай болгох ажлыг эрчимжүүлэх шаардлагатай байна. Ингэхдээ зөвхөн автомашин гэхгүйгээр трактор, мотоциклийг хүртэл орхигдуулж болохгүй юм.

Ингэснээр иргэд төрийн болон хувийн тээврийн хэрэгслийг ялган таних, тэдгээрийн ашиглалтад, хамгаалалтад иргэдээс тавих хяналт хэрэгжих боломж бүрдэх юм.

Аудитаар зөвхөн суудлын авто машины илүүдлийг тооцсон бөгөөд дансанд бүртгэлтэй хөдөө аж ахуй, газар тариалангийн зориулалттай машин, механизм,

ачааны болон үйлчилгээний зориулалттай тээврийн хэрэгслийн тооцооллыг хийгээгүй болно. Иймд эдгээр хөрөнгөтэй холбоотой судалгааг хийж, илүүдэлтэй хөрөнгийг худалдан борлуулах нь зүйтэй юм.

Тоног төхөөрөмж: 2024 оны жилийн эцсийн байдлаарх тоног төхөөрөмжийн үлдэгдлийн 43.88 хувь нь 2020 оноос хойш бэлтгэсэн хөрөнгө байгаагаас харахад ТЕЗ-ийн харьяа байгууллагууд хөрөнгийн шинэчлэл хийсэн нь харагдаж байна.

Аудитаар хөрөнгийн тооллогыг хийх явцад тоног төхөөрөмжийн хүрэлцээ хангалттай, зарим сумдын алба хаагчид 2-3 компьютер эзэмшиж байна.

Сүүлийн жилүүдэд нийлүүлэгдсэн хөрөнгийн байдалд дүн шинжилгээ хийхэд төрийн байгууллагууд зөөврийн компьютерыг түлхүү бэлтгэжээ.

Энэ нь өнөөгийн цахим шилжилтийн үед хаанаас ч ажлаа хийх боломжийг олгож байгаа хэдий ч нөгөө талаасаа хөрөнгийн хамгаалалт суларч хөрөнгө дутагдах, ашиглалтын хугацаанаас өмнө хөрөнгө эвдэрч, ашиглалтгүй болох эрсдэлийг бий олгож байна.

Жишээ нь: 1 алба хаагч 2 зөөврийн компьютертой нөхцөлд гэртээ 1-г нь аваачсан байна. Зөөврийн компьютерын тухайд 1 хүнд 1 байхад л тохиромжтой гэж үзлээ.

Тавилга, эд хогшил: Сумдын нутгийн өөрөө удирдах болон нутгийн захиргааны байгууллагуудын хувьд тавилга, эд хогшилд шинэчлэл хийсэн байдал ховор байна.

Цаашид хөрөнгийн илүүдэл бий болгохгүйн тулд ТЕЗ-ийн харьяа байгууллагуудын худалдан авах хөрөнгийг аймгийн ИТХ-аар хэлэлцэн баталж, хөрөнгө бэлтгэх эх үүсвэрийг давхардуулахгүй байхад анхаарч ажиллах нь зүйтэй байна.

1.4 Хөрөнгийн шинж чанартай зүйлсийг бараа материалын дансанд бүртгэх хандлага тогтсон байна.

ТЕЗ-ийн харьяа байгууллагуудын үндсэн хөрөнгө, бараа материалын үлдэгдэлд хяналтыг хэрэгжүүлэхэд хөрөнгийн ангиллыг зөв хийдэггүй, хөрөнгийн шинж чанартай зүйлсийг бараа материалын дансанд бүртгэдэг, хөрөнгийн засварыг тусдаа хөрөнгө мэтээр бүртгэсэн, барилга байгууламжийн зураг төслийг хөрөнгийн дансанд бүртгэсэн зөрчил нийтлэг байна.

Санхүү, бүртгэлийн алба хаагчидтай уулзалт, ярилцлага хийхэд ямар хөрөнгийг аль дансанд бүртгэх, үндсэн хөрөнгө, бараа материалыг ялган таних талаарх ойлголт дутмаг байдал ажиглагдлаа. Иймд байгууллагын төсөв захирагч, санхүүгийн алба хаагчдад эд хөрөнгөтэй холбоотой эрх зүйн зохицуулалтын талаар сургалт хийж, нэгдсэн ойлголттой болох хэрэгцээ байгаа нь харагдаж байна.

Мөн хөрөнгийг кодолж, нэрийг тодорхой ойлгомжтой байдлаар оруулдаггүй байдал байна. Энэ нь хөрөнгийн тооллого хийхэд хүндрэлтэй нөхцөл байдлыг үүсгэхээс гадна эд хариуцагч, нягтлан бодогч нар солигдсон нөхцөлд эд хөрөнгөө танин мэдэхгүй байх, хөрөнгө солигдох эрсдэлийг үүсгэж байна.

Иймд бүх төсөвт байгууллагууд эд хөрөнгийн бүртгэл хөтлөлтийн эмх цэгцийг ханган ажиллах нь зүйтэй юм.

Хүснэгт 5. Бараа материалын үлдэгдэл сая.төг

Он	Нийт үлдэгдэл	Үүнээс									
		Тусгай зориулалтын материал	Эм боох материал	Бэлэн бүтээгдэхүүн	Бичиг хэргийн материал	Аж ахуйн материал	Сэлбэг хэрэгсэл	Түлш, шатлах тослох материал	Барилгын засварын материал	Бусад хангамжийн материал	Мал, амьтад
2020	1,095.95	37.25			48.21	501.08		39.93	11.76	266.36	167.36
2021	1,149.10	46.96	2.00	0.11	53.39	547.89	39.60	20.81	22.11	304.39	111.85
2022	1,612.11	95.33	2.00	0.92	55.54	798.60	27.66	22.95	23.70	486.68	98.72
2023	2,055.10	194.14	2.00	0.89	62.62	899.85	43.73	86.63	30.13	638.78	93.34
2024	2,756.27	142.00	2.43	0.89	69.13	1,178.97	57.94	77.53	50.01	1,100.85	76.44

Эх сурвалж: ТЕЗ-ийн нэгтгэсэн тайлан

Бараа материал гэдэг нь 1-2 жилийн хугацаанд ашиглагдах, түргэн элэгдэх шинж чанартай зүйлс байдаг тул материалын дансны үлдэгдэл маш бага түвшинд байх нь зохимжтой юм. Гэтэл зарим төсөвт байгууллагуудын материалын үлдэгдэл өндөр дүнтэй байна. Энэ нь нэг талаас хөрөнгийн шинж чанартай зүйлсийг бүртгэсэнтэй холбоотой хэдий ч нөгөө талаас тухайн тайлант онд зарцуулсан материалын үлдэгдлийг тухай бүр зарлагаддаггүй, урсгал засварын шинжтэй зүйлсийг үлдэгдлээр тайлагнадаг зэрэгтэй холбоотой байна.

Үүнд:

- Урсгал засварын шинжтэй /хулдаас, паар, паркет шал, хаалга, цонх, будаг, авто машины төрөл бүрийн сэлбэг хэрэгсэл, аккумулятор, дугуй, машины мотор/ ,
- Материал гэж үзэн үлдэгдлээр бүртгэн тоолох боломжгүй зүйлс /тоон гарын үсэг, төрөл бүрийн цаасан болон хөөсөн самбар, хулдаасан хэвлэл, анонс, жаазтай зураг, замын тэмдэг тэмдэглэгээ, гадар, дотор, хаалганы хаяг/
- Худалдан авч нөөцлөөд байх шаардлагагүй материал /төрөл бүрийн хавтас, гэрэл, цахилгааны утас, вок, саван, алчуур, сав баглаа боодол/ гэх мэт байна.
- Хөрөнгийг бараа материал, үндсэн хөрөнгөнд давхар бүртгэсэн

Ийнхүү хөрөнгийг зөв ангилж бүртгэхгүй байгаа нь дараах эрсдэлийг бий болгож байна.

- ✓ Бараа материалын үлдэгдэл өндөр байх
- ✓ Хөрөнгийн шинж чанартай зүйлсийг бараа материалын дансаар дамжуулан холбогдох эрх бүхий байгууллагын шийдвэргүй зарлагадах
- ✓ Зөвхөн байгууллагын даргын шийдвэрээр данснаас хасах,
- ✓ Хөрөнгийн хамгаалалт алдагдаж, хөрөнгө үргүйдэх, дутагдах зэрэг байна.

Аудитаар хөрөнгө, бараа материалын зөв ангилж бүртгээгүйтэй холбоотой 1,902.59 сая төгрөгийн, үндсэн хөрөнгийн засварыг тусдаа хөрөнгө мэт бүртгэсэн

332.11 сая төгрөгийн, урсгал засварын шинжтэй зүйлсийг бараа материал дансанд үлдэгдлээр тайлагнасан 102.0 сая төгрөгийн зөрчил тус тус илэрсэн.

/Судалгаа 5, Судалгаа 6-д дэлгэрэнгүй харуулав/

ЗОРИЛТ 2. ХӨРӨНГИЙГ БОГИНО ХУГАЦААНД ЭЛЭГДҮҮЛЭН, ДАНС БҮРТГЭЛЭЭС ХАСДАГ НИЙТЛЭГ ЗӨРЧИЛ БИЙ БОЛСОН БАЙНА.

2.1 Үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацааг цөөхөн жилээр тогтоох хандлага тогтсон байна.

Үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацааг тогтоохдоо төсөвт байгууллагууд Сангийн сайдын 2018 оны 207 дугаар тушаалаар баталсан аргачлалыг баримталж байна. Уг аргачлалд сайн буюу шинэ, дундаж буюу цаашид ашиглах боломжтой хөрөнгийг дахин үнэлэхэд баримтлах хугацааг тогтоож өгчээ.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа байгууллагуудын хөрөнгийн элэгдэл тооцох хугацааг дээрх аргачлалын дагуу тогтоосон эсэхийг аудитын хамрах хугацаа буюу 2020 оноос хойш дансанд тусгасан хөрөнгүүдийн хүрээнд судлан үзэхэд зарим хөрөнгийн элэгдэл тооцох хугацааг огт оруулаагүй, ижил төрлийн хөрөнгийг өөр өөр хугацаанд элэгдүүлдэг, аль болох цөөхөн жилээр ашиглалтын хугацааг тогтоосон байна.

Тухайлбал:

- Барилга байгууламжийн хувьд барилгын хийц, материалаас хамааран хугацааг тодорхойлохоор заасан байна. 2020-2024 онд барилга, байгууламж дансанд оффисын зориулалттай 5,302.72 сая төгрөгийн 20 хөрөнгө бүртгэгдсэнээс 3,980.32 сая төгрөгийн 16 буюу 80 хувь нь элэгдлийн хугацааг 10-50 жилээр бага тогтоосон байна. Жишээ нь: Ургамал сумын ЗДТГ-ын барилга 2022 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар баригдсан бөгөөд уг барилгын ашиглах хугацааг 70 жилээр тогтоохоор байхад 20 жилээр тогтоосон байна. Мөн үйлчилгээ, олон нийтийн зориулалттай барилга, нийтийн эзэмшлийн талбайн байгууламж, гүүр, бусад байгууламжуудын элэгдэл тооцох хугацааг судлан үзэхэд 65 орчим хувь нь буруу тогтоосон байна.

- Тээврийн хэрэгслийн хувьд зориулалтаас хамааран элэгдэл тооцох хугацаа өөр өөр байна. Төсөвт байгууллагуудын ачааны болон суудлын авто машин, хөдөө аж ахуй, газар тариалангийн зориулалттай ковш, тракторын элэгдэл тооцох хугацааг өөр өөр тогтоосон бөгөөд дундаж хугацаа 7 жил байгаа нь аргачлалд заасан дундаж үнэлгээтэй тээврийн хэрэгслийн элэгдэл тооцох хугацаанаас бага байна. Харин мотоциклийн элэгдэл тооцох хугацаа нь тодорхой бус бөгөөд байгууллагууд 3-10 жилээр тогтоосон байна.

- Тоног төхөөрөмжийн хувьд байгууллагын үйл ажиллагааны онцлогоос хамааран төрөл бүрийн тоног төхөөрөмж худалдан авсан байна. Үүнээс байгууллагуудын өдөр тутмын үйл ажиллагаанд тогтмол хэрэглэгддэг компьютер, принтерийн элэгдэл тооцох хугацаанд ажиглалт хийхэд эдгээр хөрөнгийг 3-5 жилээр элэгдэх тооцох хугацааг тогтоосон байна. Энэ нь журамд заасан хугацаанаас 4-5

жилээр бага байна. Төсөвт байгууллагууд тоног төхөөрөмжид нэлээд шинэчлэл хийсэн байдал аудитаар ажиглагдлаа. Өөрөөр хэлбэл тоног төхөөрөмж дансны 2024 оны үлдэгдлийн 45 орчим хувь нь 2020 оноос хойш бэлтгэгдсэн байна.

- Тавилга, эд хогшлын элэгдэл тооцох дундаж хугацаа 7 жил байгаа нь аргачлалд заасан хугацаанаас 5 жилээр бага байна.

Ийнхүү үндсэн хөрөнгийн элэгдэл тооцох хугацаа богино хэмжээгээр тогтоож байгаа нь хөрөнгийг цаашид ашиглах боломжтой байхад данснаас хасах, хувьдаа завших, төсвийн хөрөнгө үргүй зарцуулагдах, үлдэх өртөггүй хөрөнгө ихсэх эрсдэлийг бий болгож байна.

Иймд эрх бүхий байгууллагууд хөрөнгийн ашиглалтад тавих хяналтыг сайжруулж, элэгдлийн хугацааг бодитой эсэхийг нягтлах, засаж залруулах шаардлагатай байна.

/судалгаа 7, судалгаа 8-д дэлгэрэнгүй харуулав/

2.2 Ашиглалтын хугацаа дууссан хөрөнгийг дахин үнэлж, ашиглалтыг сайжруулах арга хэмжээ авч эхэлсэн байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа байгууллагуудын 2024 оны байдлаарх хөрөнгийн 12.1 орчим хувь буюу 9,927.62 сая төгрөгийн хөрөнгө үлдэх өртөггүй байна. Үүний 488.24 сая төгрөгийн үлдэх өртөггүй хөрөнгө нь 2020 оноос хойш бэлтгэсэн хөрөнгө байна. Ийнхүү 2020 оноос хойш бэлтгэсэн хөрөнгийн өртөг элэгдлээрээ нөхөгдсөн байгаа нь:

- ✓ Элэгдэл тооцох хугацааг буруу тогтоосон
- ✓ Дахин үнэлсэн хөрөнгийг бүртгэхдээ ашиглалтад орсон огноог өөрчлөөгүй, анх бүртгэсэн огноогоор дахин бүртгэсэн
- ✓ Балансаас шилжүүлсэн хөрөнгийг бүртгэхдээ ашиглалтын хугацаа, хуримтлагдсан элэгдлийг буруу бүртгэсэн зэрэгтэй холбоотой байна.

Аудитаар төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа байгууллагуудын хөрөнгийн хөдөлгөөнийг судлан үзэхэд хөрөнгийг дахин үнэлж, ашиглалтын хугацааг сунгах хандлагатай болж буй байдал ажиглагдлаа. Гэхдээ хөрөнгийг дахин үнэлэхдээ элэгдэл тооцох хугацааг хэт богино тогтоож байна гэж үзлээ.

Аудитад хамрагдсан 64 байгууллагын 2020-2024 оны санхүүгийн тайлан тодруулга дахь хөрөнгийн хөдөлгөөнд ажиглалт хийхэд 16 буюу 25 хувь нь хөрөнгөнд дахин үнэлгээ хийсэн байна.

2.3 Хандив тусламж, хөрөнгө оруулалтын хүрээнд бий болсон хөрөнгийг хэнд эзэмшүүлэх, хэрхэн ашиглах нь тодорхой бус байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа байгууллагууд 2020-2024 оны хооронд хандив, тусламж, хөрөнгө оруулалтаар 36,193.62 сая төгрөгийн хөрөнгө олж бэлтгэсэн байна.

Хүснэгт 6. Хандив, тусламж, хөрөнгө оруулалтаар нийлүүлэгдсэн хөрөнгө сая.төг

ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧИЙН ХАРЬЯА БАЙГУУЛЛАГУУДЫН ХӨРӨНГИЙН АШИГЛАЛТ, ХАМГААЛАЛТ

д/д	Он	Барилга байгууламж	Тээврийн хэрэгсэл	Машин тоног төхөөрөмж	Тавилга, эд хогшил	Бусад биет бус хөрөнгө	Бусад үндсэн хөрөнгө	Программ хангамж	Нийт дүн
1	2020	272.23	240.50	347.32	28.60		71.54	8.45	968.65
2	2021	1,366.20	320.07	186.41	63.99		166.20	3.15	2,106.02
3	2022	4,512.07	988.13	492.18	108.88	891.20	918.54	7.20	7,918.20
4	2023	2,687.93	1,140.22	1,957.14	174.70	275.28	1,829.69	29.91	8,094.87
5	2024	3,989.92	5,557.89	3,040.28	570.65	1,536.54	2,406.06	4.54	17,105.88
ДҮН		12,828.35	8,246.81	6,023.33	946.82	2,703.02	5,392.03	53.25	36,193.62
Зөрүү		3,717.69	5,317.39	2,692.96	918.22	1,536.54	2,334.52	44.80	16,137.23
Өсөлт %		93.18	95.67	44.71	96.98	56.85	43.29	84.13	44.59

Дээрх хүснэгтээс харахад орон нутагт хөрөнгө оруулалт 2020 онтой харьцуулахад 44.59 хувийн өсөлттэй байна.

Ийнхүү хөрөнгө оруулалт нэмэгдэхийн хэрээр ашиглалтгүй хөрөнгө бий болох эрсдэл өндөр, улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар нийлүүлэгдсэн хөрөнгүүдийн ашиглалт, хамгаалалт хангалтгүй байна.

Үүнд: Хог шатаах зуух, хөдөө аж ахуйн техник, хэрэгсэл, тоног төхөөрөмж, арьс шир үйлдвэрлэх тоног төхөөрөмж гэх мэт байна. Эдгээр хөрөнгүүдийн ашиглалт дараах нөхцөл байдалтай байна.


Үүнд:

✓ Хог шатаах зуухны хувьд орон нутагт ашиглах ямар ч боломжгүй, хэрэн ашиглах нь тодорхой бус, ил задгай ямар ч хамгаалалтгүй байна. Иймд уг хөрөнгийг тоногдож, эвдэрч гэмтэхээс өмнө хэрэгцээтэй газарт шилжүүлэх нь зүйтэй байна.

✓ Хөдөө аж ахуйн тоног төхөөрөмжийг иргэд, хуулийн этгээдэд гэрээгээр эзэмшүүлэх талаарх төсөв захирагч нарын санаачилга хангалтгүй, төлбөрийн нөхцөлөө бодитой тодорхойлоогүй байна. Иймд сумдын төсөв захирагч нарт төрийн өмчийг бусдад хэрхэн ашиглуулах талаар чиглэл өгч, арга зүйгээр ханган ажиллах шаардлагатай байна.

✓ Арьс, шир үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжийн ашиглалт хангалтгүй байна. Энэ нь тус тоног төхөөрөмжийг ажиллуулах иргэн, хуулийн этгээд ховор байгаатай холбоотой байна. Иймд мөн хөрөнгийг хэрэгцээтэй газарт шилжүүлэн ашиглалтыг сайжруулах шаардлагатай байна.

График 3. Хөрөнгө оруулалт хөрөнгийн нэр төрлөөр



Төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа байгууллагуудад хандив тусламж, хөрөнгө оруулалтаар нийлүүлэгдсэн хөрөнгийн тулгалт хийхэд 2024 онд Сангийн яамнаас сумдын санхүүгийн албанд олгосон зөөврийн компьютерыг зарим байгууллагууд, сумдын орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар нийлүүлэгдсэн тээврийн хэрэгсэл, улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн шинэ сум төслүүд /Алдархаан, Отгон/, сумдын түүхэн ойн хүрээнд иргэд, олон нийтээс хандивласан хөрөнгийг бүртгээгүй зөрчил илэрсэн.

/Судалгаа-9-д дэлгэрэнгүй харуулав/

Үүнээс гадна ТЕЗ-ийн эрх хэмжээний хүрээнд шийдвэрлэсэн Эрүүл мэндийн яамнаас Отгон сумын ЭМГ-т олгосон авто тээврийн хэрэгслийг Их-уул сумын ЗДТГ-т өгч данс бүртгэлд тусгалгүй өдийг хүрсэн байна. Улсын онцгой комиссын шийдвэртэй хөрөнгийг эрх мэдлээ ашиглан өөр байгууллагад олгосон нь учир дутагдалтай байна.

2.4 Эд хөрөнгийн ашиглалтын картын хөтлөлт хангалтгүй, хөдөлгөөн гарсан тухай бүр шинэчлэн хөтлөөгүй байна.

Аудитаар 24 суманд томилолтоор ажиллан төрийн байгууллагуудын 2024 оны байдлаарх хөрөнгийг нүд үзэн тоолж, эд хөрөнгийн ашиглалтын карттай тулгалт хийхэд дараах байдалтай байна.

- ✓ Хөрөнгийн ашиглалтын картыг иж бүрэн бөглөөгүй, зөвхөн тухайн алба хаагчийн эзэмшилд байгаа хөрөнгийн тоог бүртгэсэн, гарын үсгээр баталгаажуулаагүй, алба хаагчдын нэрийг бичээгүй, албан тушаалаар хөтөлсөн
- ✓ Хөрөнгийн хөдөлгөөн гарсан тухай бүр шинэчлэн хөтөлдөггүй
- ✓ Дансанд бүртгэлтэй бүх хөрөнгө, бараа материалыг картаар бүртгэх талаар ойлголт хангалтгүй, зөвхөн тухайн алба хаагчийн өдөр тутамдаа ашигладаг ширээ, компьютер, принтер, тооны машин, уртасгагч гэх мэтийг бүртгэсэн байдалтай байна.

Ийнхүү хөрөнгийн картыг бүрэн хөтөлж, дансанд бүртгэлтэй хөрөнгө, бараа материалыг эзэнжүүлээгүй улмаас хөрөнгө тоногдох, дутагдах, хөрөнгийн хамгаалалт сулрах нөхцөлийг бүрдүүлж байна.

Иймд данс бүртгэлд тусгагдсан хөрөнгийг хүн бүрд эзэмшүүлж, тухайн хөрөнгийг иргэн, хуулийн этгээдэд түр ашиглуулахдаа эд хариуцагчид мэдэгдэж, өгсөн авсан тухай баримт үйлдэж хэвших, мөн тухайн хөрөнгийн ашиглалтын явцад гарсан эвдрэл гэмтлийн шалтгааныг тодорхойлж, буруутай этгээдээр нөхөн төлүүлдэг байх шаардлагатай байна.

Аудитын явцад төрийн байгууллагуудын хөрөнгийг иргэн, хуулийн этгээд ашиглаж буй тохиолдлууд гарсан бөгөөд ингэхдээ ямар ч баримт үйлдэлгүй, аман хэлэлцээрээр ашиглуулж байна.

Энэ нь тухайн хөрөнгө эвдэрч гэмтсэн, дутагдсан тохиолдолд хариуцлага нэхэх боломжгүй байдлыг бий болгож байна.

ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧИЙН ХАРЬЯА БАЙГУУЛЛАГУУДЫН ХӨРӨНГИЙН АШИГЛАЛТ, ХАМГААЛАЛТ
2.5 Орон нутгийн өмчийг данс бүртгэлээс хасах, актлах, балансаас шилжүүлэх үйл явц хяналтгүй, урсгалаар явагдаж байна.

Аудитын хамрах хугацаанд төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа байгууллагуудын хөрөнгийг данс бүртгэлээс хасах, актлах, балансаас шилжүүлэх, дуудлага худалдаагаар худалдах тухай 60 шийдвэр гарсан байна. Үүнд:

Хүснэгт 7. Хөрөнгө данс бүртгэлээс хасахтай холбоотой шийдвэр

д/д	Шийдвэрийн төрөл	Шийдвэрийн тоо
1	Үндсэн хөрөнгийг дуудлага худалдаагаар худалдах зөвшөөрөл олгох	17
2	Үндсэн хөрөнгө балансаас балансад шилжүүлэх	20
3	Үндсэн хөрөнгө актлаж, данснаас хасах	23
	ДҮН	60

Эдгээр шийдвэрүүдийн үр дүнд шинжилгээ хийхэд:

✓ Хөрөнгийн элэгдэл тооцох хугацааг буруу тогтоосноос өртгөө богино хугацаанд нөхсөн хөрөнгийг данс бүртгэлээс хасах /акталж/, дуудлага худалдаагаар худалдан борлуулах, сэлбэг хэрэгслээр худалдах шийдвэр гаргасан нь тухайн хөрөнгийг богино хугацаанд элэгдүүлэн өөртөө болон бусдад давуу байдал олгох, төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулах эрсдэлийг бий болгож байна.

/Судалгаа 10-д дэлгэрэнгүй харуулав/

✓ Балансаас хөрөнгө шилжүүлэх шийдвэр нь тухайн хөрөнгийг хүлээн авах байгууллага данс бүртгэлд тусгасан эсвэл ашиглаж эхэлсний дараа гарсан. Энэ нь байгууллагуудын хооронд хөрөнгө дутагдах, эзэнгүйдэх эрсдэлийг бий болгож байна. /Эрдэнэхайрхан сумын ЗДТГ-с Завханмандал сумын ЗДТГ-т, Тосонцэнгэл сумын ЗДТГ-с тус сумын хот тохижилт үйлчилгээний газарт шилжүүлсэн тээврийн хэрэгсэл/

✓ Сумын бусад төсөвт байгууллагуудын ашиглалтгүй хөрөнгийг ЗДТГ-т шилжүүлэн өгсөн. Энэ нь ач холбогдол багатай, орон нутгийн өмчид ашиглалтгүй, эзэнгүй хөрөнгийг бий болгож байна. Тухайн байгууллагад нэн шаардлагатай, дутагдалтай хөрөнгүүдийг баланс хооронд шилжүүлж байх нь зүйтэй юм.

✓ Ашиглалтын хугацаа дууссан, ашиглах боломжгүй тээврийн хэрэгслийг дуудлага худалдаагаар борлуулах, сэлбэгээр худалдах зэрэг шаталсан арга хэмжээ авалгүй шууд актлаж, данс бүртгэлээс хасах шийдвэр гаргасан байна. Ингэхдээ тухайн хөрөнгийн ашиглалтын хугацаа бодитой эсэхийг хянаж үзээгүй, цаашид ашиглах боломжгүй эсэхийг нүдээр үзэж, баримтжуулдаггүй байдал ажиглагдлаа.

/судалгаа10-д дэлгэрэнгүй харуулав/

✓ Нэг хөрөнгөнд шийдвэрийг давхардуулан гаргасан байна. Тухайлбал: Эхлээд актлах шийдвэр гаргаад, дараа нь дуудлага худалдаагаар худалдах шийдвэр гаргасан. Эдгээр тээврийн хэрэгслүүдийг тухайн байгууллагууд данс бүртгэлээс хассан бөгөөд дуудлага худалдаагаар зарагдаагүй, яасан нь тодорхойгүй байна. /Тосонцэнгэл сумын ЗДТГ-ын дансанд бүртгэлтэй Норд автомашин/

✓ Байгууллагын дансанд бүртгэлтэй хөрөнгө дутагдсан, хулгайд алдагдсан, тоногдсон байхад буруутай этгээдээр нөхөн төлүүлэх арга хэмжээ авч ажиллаагүй, актлах шийдвэр гаргаж, данс бүртгэлээс хасдаг жишиг тогтох хандлагатай байна. /Тээврийн хэрэгсэл, бага оврын дизель станц/

✓ Тоног төхөөрөмж, тавилга эд хогшлыг акталж, данснаас хасах шийдвэр гаргахдаа нүд үзэж, хяналт хийлгүйгээр шийдвэр гаргаж байна.

✓ Тавилга, эд хогшлоос бусад төрлийн хөрөнгийг данс бүртгэлээс хасах асуудлыг Аймгийн ИТХ-ын шийдвэрт үндэслэхээр журамд заасан байхад сумын ИТХ-ын шийдвэрээр бусад хөрөнгийг акталж, данс бүртгэлээс хассан

✓ Байгууллагын дансанд бүртгэлтэй хөрөнгийг худалдан борлуулсан нь тодорхой бус, иргэд эзэмшиж /Асгат ЗДТГ/ байна.

✓ Бараа материалын дансанд бүртгэлтэй хөрөнгийн шинжтэй зүйлийг эрх бүхий байгууллагын шийдвэргүй данс бүртгэлээс хаасан

Ийнхүү эрх бүхий байгууллагууд шийдвэр гаргахдаа үр дагавар, нөхцөл байдлыг үнэлж, хязгаарлалт тавихгүй байгаа нь учир дутагдалтай байна.

Цаашид аливаа шийдвэр гаргахдаа бодит нөхцөл байдлыг шударгаар үнэлж, бусдад давуу байдал олгохгүй байх, төсөвт нөлөөлөх байдал, үр дагаврыг тооцоолж байх шаардлагатай байна.

2.6 Орон нутгийн өмчийг бусдад үнэ төлбөргүй өгдөг жишиг тогтох хандлагатай болсон байна.

Аудитын хүрээнд төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа 64 байгууллагын үндсэн хөрөнгийг 2024 оны жилийн эцсийн үлдэгдэлтэй тулган биет тооллогыг хийсэн. Тооллогын үр дүнгээр дараах зөрчил, дутагдал илэрлээ. Үүнд:

- ✓ Улс төрийн алба хаагчдын эзэмшиж буй хөрөнгийг тухай бүр ажил үүрэг солигдох, ажлаас чөлөөлөгдөх үед нь буцаан авч хүлээлцдэггүй, үүний улмаас хөрөнгө дутагдах, хаана байгаа нь тодорхой бус нөхцөл байдлууд үүссэн.

Аудитаар 133.1 сая төгрөгийн 82 мотоцикл бодитоор байгаа эсэх нь тодорхой бус, тооллогод хамрагдаагүй байна. Энэ нь багийн дарга нар солигдохдоо хэрэглэж байсан хөрөнгийг буцааж өгдөггүйтэй холбоотой гэсэн тайлбарыг холбогдох алба хаагчид өглөө. Цаашид улс төрийн алба хаагчид ажлаас чөлөөлөгдсөн тохиолдолд тойрох хуудсаар холбогдох тооцоог хийж, эзэмшиж байсан хөрөнгийг санхүүд буцаан өгч, тооцоо дууссаны дараа тэтгэмжийг олгодог байх тогтолцоог бүрдүүлэх шаардлагатай байна. Ингэхийн тулд улс төрийн алба хаагчдад олгодог тэтгэмжийг тухайн байгууллагын дансаар дамжуулж байх нь зүйтэй байна.

✓ Иргэн хуулийн этгээдэд орон нутгийн өмч, хөрөнгийг ашиглуулахдаа холбогдох гэрээнүүдийг /түрээс, ашиглалт, хариуцлага/ хийгээгүй, хийсэн гэрээг архивын баримт болгон хадгалаагүй, санхүүгийн алба хаагчид өгч төлбөр тооцоо бодуулаагүй байна. Энэ нь тухайн хөрөнгийг хэнд хэзээ өгснийг тодорхойлох боломжгүй, хөрөнгө дутагдах, гэрээнд төлбөр тооцооны нөхцөлийг тусгасан эсэхийг тодорхойлох боломжгүй байдлуудыг бий болгож байна.

- ✓ Төрийн байгууллагуудын тооллогын комисс хөрөнгө, бараа материалыг нүд

үзэн тоолдоггүй, нэр төдий хийдэг нь хөрөнгө дутагдах, тухайн хөрөнгө хэзээнээс алга болсныг тодорхойлох боломжгүй байдлыг бий болгож байна.

✓ Мөн сумын засаг дарга дангаараа шийдвэр гарган иргэнд төрийн өмчийг шагнал болгон өгсөн, уг хөрөнгө тухайн байгууллагын дансанд бүртгэлтэй байна. /Сантмаргаз сум-орон сууц/

Аудитаар дээрх нөхцөл байдалтай холбоотой 578.43 сая төгрөгийн хөрөнгө дутагдсан зөрчил илэрсэн. [/Судалгаа-11 д дэлгэрэнгүй харуулав/](#)

Үүнээс:

- Холбогдох эрх бүхий байгууллагад хүргүүлсэн 2025 онд данс бүртгэлээс хасах саналд тусгасан 40.08 сая төгрөгийн 24 мотоцикл, 71.2 сая төгрөгийн 2 суудлын автомашин, 33.21 сая төгрөгийн 3 трактор, 4.6 сая төгрөгийн 5 нэр бүхий тоног төхөөрөмж, нийт 149.09 сая төгрөгийн хөрөнгөнд зөвлөмж,
- Алба хаагчдад шинээр хөрөнгө олгохдоо өмнө нь ашиглаж байсан хөрөнгө ашиглах боломжтой эсэхийг тодорхойлоогүй, бодитоор байгаа эсэх нь тодорхой бус, аудитын тооллогод хамрагдаагүй 93.02 сая төгрөгийн 58 мотоцикл, хэнд, хэзээ өгч эзэмшүүлсэн нь тодорхой бус, аудитын тооллогод хамрагдаагүй 44.93 сая төгрөгийн 8 трактор, 15.0 сая төгрөгийн 2 механизм, 9.56 сая төгрөгийн 3 тоног төхөөрөмж, нийт 166.95 сая төгрөгийн хөрөнгөнд албан шаардлага,
- Хулгайд алдагдан хууль хяналтын байгууллагад шалгагдаж буй 60.0 сая төгрөгийн хөрөнгөнд албан шаардлага
- Аудитын тооллогоор дутагдсан 37.21 сая төгрөгийн 2 тээврийн хэрэгсэл, 147.7 сая төгрөгийн 2 цахилгаан станцыг хууль хяналтын байгууллагад шилжүүлэн, эзэн холбогдогчийг олж тогтоон нөхөн төлүүлэх албан шаардлага,
- Аудитын тооллогоор дутагдсан, анхнаасаа нийлүүлэгдээгүй хөрөнгийг данс бүртгэлд тусгасантай холбоотой 17.48 сая төгрөгийн 9 нэр төрлийн тоног төхөөрөмж, тавилга эд хогшил, бусад үндсэн хөрөнгөнд төлбөрийн акт тогтоохоор шийдвэрлэлээ.

2.7 Орон нутгийн өмчийг худалдан борлуулах дуудлага худалдааг хууль журмын дагуу зохион байгуулсан эсэхэд дүгнэлт өгөх боломжгүй байна.

Аймгийн ИТХ-аас 2020-2024 оны хооронд төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа байгууллагуудын үндсэн хөрөнгийг дуудлага худалдаагаар борлуулах, сэлбэг хэрэгслээр зарахтай холбоотой 17 шийдвэр гарсан байна.

Хүснэгт 8. Дуудлага худалдаагаар худалдах хөрөнгийн тоо /сая.төг/

д/д	Огноо	Шийдвэрийн тоо	Барилга, байгууламж		Тээврийн хэрэгсэл			
					Дуудлага худалдаагаар борлуулах		Сэлбэг, хэрэгслээр худалдах	
			тоо	Өртгийн дүн	тоо	Өртгийн дүн	тоо	Өртгийн дүн
1	2020	5	6	203.24	6	144.59		
2	2021	3	1	14.06	4	76.02	2	80.0
3	2022	2	2	23.61	20	374.16		
4	2023	2	3	189.49	6	88.33		
5	2024	5	0	0	13	216.57	4	110.9
	ДҮН	17	12	430.4	49	899.67	6	190.9

Дуудлага худалдаагаар нийт 1,520.97 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 67 хөрөнгийг худалдан борлуулах ажлыг зохион байгуулснаас 53 хөрөнгийг худалдан борлуулсан байна.

Дуудлага худалдааг хууль журмын дагуу зохион байгуулсан эсэхэд дүгнэлт өгөх боломжгүй нөхцөл байдал үүссэн. Учир нь уг арга хэмжээтэй холбоотой архивын баримтын эмх цэгц хангалтгүй, мэдээлэл олж авахад хүндрэлтэй, ирүүлсэн баримтаас харахад нэр бүхий цөөхөн иргэд дуудлага худалдаанд тогтмол оролцсон байдалтай байлаа.

Цаашид архивын баримтын эмх цэгцэд анхаарч, ойлгомжтой байдлаар баримтыг бүрдүүлж ажиллах шаардлагатай байна.

2.8 Орон нутгийн өмчийг бусдад ашиглуулсны /түрээсийн/ төлбөрийг төсөвт бүрэн төвлөрүүлээгүй байна.

Орон нутгийн өмчийн дансанд түрээсийн орлогоор 71.69 сая төгрөг төвлөрүүлсний 55.02 сая төгрөг буюу 76.75 хувь нь төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа байгууллагуудаас төвлөрүүлсэн байна. .

Хүснэгт 9. Түрээсийн орлого /сая.төг/

д/д	Он	Нийт түрээсийн орлого	Үүнээс: ТЕЗ-ийн харьяа байгууллагуудаас
1	2020	1.72	0
2	2021	8.20	6.52
3	2022	9.51	7.43
4	2023	23.36	19.38
5	2024	28.9	21.69
	ДҮН	71.69	55.02

Түрээсийн орлого нь ихэвчлэн төрийн байгууллагуудын конторын өрөө, тасалгааг бусдад түрээслүүлсний орлого байна.

Орон нутгийн өмчийн түрээсийн гэрээ байгуулахдаа м2-ын төлбөрийн хэмжээг байгууллага бүрд өөр өөр дүнгээр тооцсон байна.

Аймгийн ИТХ-ын хуралдааны 2019 оны 51 дугаар тогтоолоор м2-ын төлбөрийн хэмжээг тогтоож өгсөн бөгөөд тухайн төлбөрийн хэмжээг баримтлан ажиллаагүй, зарим түрээслэгч нартай шууд тохиролцон гэрээ хийсэн байна гэж үзлээ.

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2020 оны 50 дугаар тогтоолоор “төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийн түрээсийн гэрээ”-ний үлгэрчилсэн загварыг шинэчлэн баталж, түрээсийн төлбөрийн 40 хувийг орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр тусгасан байхад аймгийн ИТХ-ын хуралдаанаар баталсан журам болон гэрээнд өөрчлөлт оруулаагүй байна.

Иймд дээрх журамд өөрчлөлт оруулан, гэрээний шинэчилсэн загвараар түрээслэгч нартай гэрээг байгуулан ажиллах нь зүйтэй байна.

Орон нутгийн өмчийн түрээсийн 2024 онд байгуулсан гэрээний хэрэгжилтэд хяналт хэрэгжүүлэхэд гэрээг санхүүгийн жилээр байгуулаагүй, гэрээний дагуу түрээсийн орлого бүрэн төвлөрөөгүй, түрээслэгч байгууллагуудтай тооцоо нийлж үлдэгдлийг баталгаажуулсан баримт үйлдээгүй, архивын нэгж үүсгээгүй нөхцөл байдалтай байна.

Түрээсийн орлогоор 2024 онд нийт 91.2 сая төгрөгийн орлого, үүнээс орон нутгийн төсөвт 28.9 сая төгрөг /30%/ төвлөрүүлэхээс 21.69 сая төгрөг төвлөрүүлсэн байна.

/Судалгаа 12-т дэлгэрэнгүй харуулав/

Төвлөрүүлээгүй үлдэгдлийг судлан үзэхэд гэрээний үүргээ биелүүлэн ажиллаагүй түрээслэгчийг хууль хяналтын байгууллагад шилжүүлсэн тохиолдол байна.

Сумын ЗДТГ хуучин конторын барилга, ахуйн үйлчилгээний төв, халуун ус, худаг, бохир усны машин зэргийг иргэдэд үнэ төлбөргүйгээр ашиглуулж байна. Цаашид дээрх хөрөнгүүдийг иргэн, хуулийн этгээдэд ашиглуулсан нөхцөлд тодорхой хэмжээний төлбөр авбал төсвийн хөрөнгө нэмэгдэж, хөрөнгийн ашиглалт, хамгаалалт сайжрах боломж байна гэж үзлээ.

Зарим сумд хөдөө аж ахуйн техник хэрэгслийг хуулийн этгээдэд түрээсээр эзэмшүүлсэн ч гэрээний нөхцөл /төлбөр/ хангагдаагүй байна.

2.9 Орон нутгийн өмчийг худалдан борлуулсны орлогыг төсөвт бүрэн төвлөрүүлээгүй байна.

Аудитын хамрах хугацаанд эрх бүхий байгууллагын 17 шийдвэрээр 67 нэр бүхий 1,520.97 сая төгрөгийн төсөвт өртөгтэй хөрөнгийг нээлттэй дуудлага худалдаа, сэлбэг хэрэгслээр худалдсанаас орон нутгийн төсөвт 454.05 сая төгрөг төвлөрүүлэхээр байна. Үүнээс 39.86 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 2 тээврийн хэрэгслийг балансаас шилжүүлсэн, 120.44 сая төгрөгийн 12 нэр бүхий хөрөнгө зарагдаагүй байна.

Дуудлага худалдааны орлогыг хөрөнгийн нэр, төрөл бүрээр дансны хуулгаар тулгалт хийхэд дараах нөхцөл байдалтай байна.

- Хөрөнгийн дуудлага худалдааны дэнчингийн мөнгийг дансанд тухай бүр тушаагаагүй,
- Худалдах, худалдан авах гэрээний дүнтэй дансаар орсон орлогыг тулган тооцоо бодоогүй,
- Дуудлага худалдаагаар зарагдсан хөрөнгийн төлбөрийг орон нутгийн төсөвт төвлөрүүлээгүй,
- Сэлбэг, хэрэгслээр худалдсан хөрөнгийн орлого болон хулгайд алдсан хөрөнгийг буруутай этгээдээр нөхөн төлүүлсний орлогыг орон нутгийн төсөвт төвлөрүүлээгүй, тухайн байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансанд төвлөрүүлсэн зэрэг байна.
- Тээврийн хэрэгслүүд авто тээврийн төвд бүртгэлгүй, улсын дугаар олгогдоогүй нь дуудлага худалдааны төлбөр төлөгдөхгүй байх эрсдэлийг бий болгож байна.

Дуудлага худалдааны орлого бүрдүүлэлтэй холбоотой асуудлыг судалгаа 13-д дэлгэрэнгүй харуулав.

Цаашид архивын баримтын эмх цэгцийг ханган ажиллаж, дуудлага худалдаа зохион байгуулсан тухай бүр хөрөнгө борлуулсны орлогыг худалдах, худалдан авах гэрээний дүнтэй тулган тооцоо нийлж баримтжуулж байх шаардлагатай байна.

2.10 Орон нутгийн өмчийн орлогын данснаас шууд зарцуулалт хийсэн байна.

Орон нутгийн өмчийн дансанд түрээсийн болон хөрөнгө худалдан борлуулсны орлого төвлөрсөн байна.

Хүснэгт 10. Орон нутгийн өмчийн орлого /сая.төг/

д/д	Он	Дүн
1	2020	86.43
2	2021	69.72
3	2022	58.76
4	2023	56.36
5	2024	449.32
	ДҮН	720.59

Орон нутгийн өмчийн орлогоос аймгийн ИТХ-ын нэмэлт дансаар дамжуулан тухайн жилийн орлогын 30 хувийг зарцуулсан, мөн тухайн данснаас сумдын ЗДТГ-ын нэмэлт дансанд хөрөнгө шилжүүлсэн тохиолдлууд 2020, 2021 онуудад гарсан байна.

2022 оноос хойш дээрх зөрчил арилсан бөгөөд орон нутгийн өмчийн орлогоос дуудлага худалдаа зохион байгуулахтай холбоотой зар мэдээлэл, бичиг хэргийн зардлыг гаргаж, үлдсэн хэсгийг орон нутгийн төсөв төвлөрүүлсэн байна.

Орон нутгийн төсвийн орлого бүрдүүлж буй данснаас шууд зарцуулалт хийх нь учир дутагдалтай тул орон нутгийн өмчийн газрын үйл ажиллагаанд шаардлагатай зардлыг төсөвт тусган баталж байх нь зүйтэй байна.

ЗОРИЛТ 3. ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН АШИГЛАЛТ, ХАМГААЛАЛТАД ТАВИХ ХЯНАЛТ ХАНГАЛТГҮЙ БАЙНА.

3.1 Аймаг, сумдын ИТХ нь өмч хөрөнгөтэй холбоотой шийдвэрийн хэрэгжилтэд хяналт хэрэгжүүлээгүй байна.

Аймгийн ИТХ-аас орон нутгийн өмчид орлого олж бэлтгэх, данс бүртгэлд тусгах, данс бүртгэлээс хасахтай холбоотой 5 төрлийн 69 шийдвэр гаргасан байна.

Хүснэгт 11. Аймгийн ИТХ-аас гарсан шийдвэр /сая.төг/

ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧИЙН ХАРЬЯА БАЙГУУЛЛАГУУДЫН ХӨРӨНГИЙН АШИГЛАЛТ, ХАМГААЛАЛТ

д/д	Он	Үндсэн хөрөнгө олж авах зөвшөөрөл		Үндсэн хөрөнгө бүртгэх зөвшөөрөл		Үндсэн хөрөнгийг дуудлага худалдаагаар худалдаалах зөвшөөрөл		Үндсэн хөрөнгө балансаас шилжүүлэх зөвшөөрөл		Үндсэн хөрөнгө акталж, данснаас хасах зөвшөөрөл	
		Шийдвэрийн тоо	Өртгийн дүн	Шийдвэрийн тоо	Өртгийн дүн	Шийдвэрийн тоо	Өртгийн дүн	Шийдвэрийн тоо	Өртгийн дүн	Шийдвэрийн тоо	Өртгийн дүн
1	2020	2	3.02			5	347.83	5	269.64	8	382.72
2	2021	5	76.26			3	170.08	4	849.35	3	314.34
3	2022			1	75.35	2	397.77	1	244.16	3	407.94
4	2023			1	861.88	2	277.82	5	259.92	4	314.16
5	2024					5	327.47	5	219.04	5	312.98
	ДҮН	7	79.28	2	937.23	17	1520.97	20	1842.11	23	1732.14

Эдгээр шийдвэрийн хэрэгжилтийг байгууллага бүрээр, хөрөнгө тус бүрийг тулган үзэхэд дараах нөхцөл байдалтай байна.

❖ Улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар нийлүүлэгдсэн, аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр бий болсон хөрөнгийн шинж чанартай зүйлс, барилгын засварыг данс бүртгэл тусгах шийдвэрийг 2022, 2023 онуудад гаргасан байна. Шийдвэрийн хэрэгжилтийг хянахад үндсэн хөрөнгийн өртгийг засвар хийсэн дүнгээр нэмэгдүүлээгүй, тусдаа хөрөнгө мэтээр бүртгэсэн, тоног төхөөрөмжийн үнийн дүнг зөрүүтэй, нэг бүрчлэн салгаж бүртгээгүй бөөн дүнгээр багцалж тусгасан байна.

❖ Дуудлага худалдаагаар зарах шийдвэр гарсан хөрөнгийн зарагдсан эсэх талаарх мэдээллийг тухайн байгууллагад албан бичгээр хүргүүлдэггүйн улмаас төсөвт байгууллагууд тухайн хөрөнгийг зарагдсан эсэхээс үл хамааран данс бүртгэлээс хасаж байна. / Цэцэн-Уул сумын ЗДТГ 11 айлын орон сууц, Сонгино сумын ЗДТГ трактор/ Мөн зарагдсан байхад хасаагүй тохиолдол байна.

❖ Балансаас хөрөнгө шилжүүлэх шийдвэрийн хувьд шилжүүлж буй байгууллага тухай бүр данс бүртгэлээс хөрөнгийг хассан байхад хүлээн авагч байгууллага данс бүртгэлд тусгаагүй тохиолдлууд байна. Энэ нь байгууллагуудын дунд хөрөнгө үрэгдэх, дутагдах, эзэнгүйдэх эрсдэлийг бий болгож байна. Тухайн хөрөнгө 2 байгууллагын дансанд давхар бүртгэгдсэн тохиолдол ч байна.

❖ Данс бүртгэлээс хөрөнгө акталж хасахдаа шийдвэрийн дүнгээс зөрүүтэй, илүү дутуу зарлагдсан

❖ Эрх бүхий байгууллагаас гарсан шийдвэр тухай бүр хэрэгжээгүй байна. Тухайлбал: аль 2017, 2018 онуудад гарсан шийдвэр 2021, 2022 онд хэрэгжсэн байна.

Ийнхүү эрх бүхий байгууллагаас гарсан шийдвэрийн хэрэгжилт хангалтгүй байгаа нь төрийн байгууллагуудын хоорондын уялдаа холбоо, мэдээлэл түгээх суваг тодорхой бус, эрх бүхий байгууллагаас гаргасан шийдвэрийг тухай бүр холбогдох байгууллагуудад хүргүүлдэггүй, хэрэгжилтийг эргэн хянаж баримтжуулдаггүй зэрэгтэй холбоотой байна. Мөн шийдвэрийн хэрэгжилтэд хяналт хэрэгжүүлээгүйн улмаас хөрөнгө данс бүртгэлд тусгагдахгүй орхигдох, дундаас нь үрэгдэх, алга болох, дутах эрсдэлийг бий болгож байна.

Эрх бүхий байгууллагаас гаргасан шийдвэрийн хэрэгжилтийг судалгаа 14-д дэлгэрэнгүй харуулав

Иймд цаашид дараах арга хэмжээг авч ажиллах нь шаардлагатай байна гэж үзлээ. Үүнд:

- Улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт, аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр бий болсон хөрөнгийг данс бүртгэлд тусгах тухай шийдвэрийг тогтмол гаргаж, хэрэгжилтэд хяналт тавьж байх
- Дуудлага худалдаагаар тухайн байгууллагын хөрөнгө зарагдсан нөхцөлд худалдах, худалдан авах гэрээ, төлбөр төлсөн баримтыг эзэмшигч байгууллагад хүргүүлж, хэрэгжилтэд хяналт тавьж байх. Мөн тухайн хөрөнгө зарагдаж, гэрээ байгуулагдсан нөхцөлд данс бүртгэлээс хасаж байх талаар арга зүйгээр хангаж ажиллах,
- Шийдвэрийн биелэлтийг хянаж, баримтжуулан архивын нэгж үүсгэн ажиллах зэрэг байна.

3.2 Эрх бүхий байгууллагуудаас өмч хөрөнгийн ашиглалтад хамгаалалтад хяналт хийгээгүй байна.

Аймаг, сумын ИТХ нь орон нутгийн хөрөнгийн өмчлөгч, эд хөрөнгийн хадгалалт, хамгаалалтын байдлыг хянан шалгах, түүнд тавих хяналт шалгалтыг зохион байгуулах эрх бүхий байгууллага билээ. Тус байгууллага эрхээ бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Мөн орон нутгийн өмчийн эзэмшилт, ашиглалт, хадгалалт, хамгаалалтад хяналт тавих эрх бүхий байгууллага нь Орон нутгийн өмчийн газар нь үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэхэд хүний болон санхүүгийн нөөц хүрэлцэхгүй, эрх мэдэл багатай байдаг боловч санал санаачилгаатай ажиллах хэрэгтэй байна гэж үзлээ.

Орон нутгийн өмчийн газар нь орон нутгийн төсвөөс санхүүждэг, төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа байгууллага учир ТЕЗ-н зүгээс менежментийг сайжруулах, нөөцийн дэмжлэг үзүүлэн ажиллах шаардлагатай байна.

Аудитаар сумдад ажиллах явцад төсөвт байгууллагуудын хөрөнгийн хадгалалт хангалтгүй, хөрөнгө хулгайд алдагдсан, тоногдсон, хаана, хэн эзэмшиж, ашиглаж байгаа нь тодорхой бус, тээврийн хэрэгслийг хэн дуртай нь унаж үргүй зардал гаргадаг /амралтын хугацаандаа төрийн машин ашигладаг, машины түлхүүрийг хувилж хулгайгаар унадаг, тээврийн хэрэгсэл ашиглах эрхгүй алба хаагчид тээврийн хэрэгсэл ашигладаг/, эвдрэл гэмтлийг буруутай этгээдээр нөхөн төлүүлдэггүй байдлууд ажиглагдсан.

Мөн хөрөнгө оруулалт, худалдан авалттай холбоотой төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа байгууллагуудын тээврийн хэрэгсэл, техник, тоног төхөөрөмж ихсэж, тухайн хөрөнгүүдийг хадгалах агуулах, зоорины хүрэлцээ хангалтгүйгээс иргэн, айл өрхийн хашаанд байршуулсан, орон гэртээ аваачиж хадгалсан нь дээрх нөхцөл байдал үүсэх үндсийг бий болгож байна.

Иймд сум бүрд дор хаяж тээврийн хэрэгсэл, техник, тоног төхөөрөмжийг нэг дор байршуулан хадгалах хашаа, агуулахын асуудлыг шийдвэрлэж, камержуулах

ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧИЙН ХАРЬЯА БАЙГУУЛЛАГУУДЫН ХӨРӨНГИЙН АШИГЛАЛТ, ХАМГААЛАЛТ
нь зүйтэй байна. Ингэснээр хөрөнгийн ашиглалт, хадгалалтад тавих хяналт сайжирч, хөрөнгө тоногдож, эвдрэх эрсдэл буурахаар байна.

3.3 Орон нутгийн өмчтэй холбоотой нэгдсэн тооллого зохион байгуулж, биелэлтийг тооцон ажиллаагүй байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд өмч хөрөнгийн нэгдсэн тооллогыг жил бүр зохион байгуулж, шат шатны ИТХ-аар дүнг хэлэлцүүлж байхаар зохицуулсан байна. Аймаг, сумдын эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас санаачлан орон нутгийн өмч хөрөнгөнд нэгдсэн тооллого хийж, үр дүнг тооцон ажиллаагүй, Орон нутгийн өмчийн газар нь жилд хэд хэдэн сумдад ажиллаж, заавар зөвлөмж өгч байгаа хэд ч дорвитой үр дүн гараагүй байна.

Улсын хэмжээнд 2022 онд төрийн болон орон нутгийн өмчийн үзлэг тооллогыг зохион байгуулсан байна. Гэсэн хэдий ч уг тооллогыг чанартай зохион байгуулаагүй байна гэж үзлээ. Уг тооллогын үр дүнгээр өгсөн зөвлөмж, тэдгээрийн мөрөөр ажил хийгээгүй байна.

Төсөвт байгууллагууд хагас бүтэн жилээр хөрөнгийн тооллого хийх комисс томилсон хэдий ч тооллогыг бодитоор хийсэн гэх үндэслэлтэй нотолгоо байхгүй байна.

Аудитаар төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа байгууллагуудын 2024 оны жилийн эцсийн хөрөнгийн үлдэгдэл, тооллогын дүнд үндэслэн биет тооллогыг хийхэд ихэнх байгууллагын эд хариуцагч, нярав, нягтлан бодогч нар хөрөнгөө хаана байгааг мэдэхгүй, хэнд эзэмшүүлсэн нь тодорхой бус, дутагдсан, бодитоор байхгүй хөрөнгүүдийг байгаагаар тоолсон нийтлэг зөрчил байна.

Иймд хөрөнгийн хагас, бүтэн жилийн тооллогыг чанартай хийж, үр дүнг өмч хамгаалах зөвлөлөөр хэлэлцүүлэн, алдаа дутагдлыг засаж залруулах, дутагдсан эд хөрөнгийг холбогдох буруутай этгээдээр нөхөн төлүүлэх ажлыг гүйцэтгэж хэвших шаардлагатай байна.

Мөн эд хариуцагч, нярав, нягтлан бодогч нар солигдсон тухай бүр эд хөрөнгийн тооллогыг бодитой хийж, ажил хүлээлцдэг байх нь зүйтэй байна.

3.4 Төрийн өмчийг эзэмшүүлэх гэрээг бодитой дүгнэн, хэрэгжилт хангалтгүй төсөв захирагч нарт хариуцлага тооцоогүй байна.

Орон нутгийн өмчийн газар нь “төрийн өмчийг эзэмшүүлэх гэрээ”-г төрийн байгууллагуудтай байгуулан, хэрэгжилтийг дүгнэсэн байна.

Гэрээний хэрэгжилтийг дүгнэхдээ ерөнхий 5 шалгуур үзүүлэлтээр дүгнэжээ. Үүнд:

1. Хөрөнгийн ашиглалт хадгалалт, хамгаалалтын байдал
2. Хөрөнгийн хөдөлгөөн, бүртгэл, мэдээ тайлан, шийдвэрийн хэрэгжилт, тайлагналтын байдал
3. Төрийн болон орон нутгийн өмчийн цахим мэдээллийн системийн байдал
4. Газар эзэмших, ашиглах эрхийн байдал

5. Гэрээний харилцааг зохицуулах журмын хэрэгжилт, бэлтгэл хангасан байдал

Аудитаар 2024 оны өмч эзэмшүүлэх гэрээний хэрэгжилтэд дүн шинжилгээ хийх зорилгоор холбогдох байгууллагаас мэдээлэл гаргуулан авахад төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа байгууллагын 50 хувь буюу 32 байгууллагын үнэлгээг аудитад ирүүлсэн. Ирүүлсэн судалгаанд үндэслэн гэрээний үнэлгээнд дүн шинжилгээ хийхэд 25 буюу 78.1 хувь нь хангалттай үнэлгээтэй үнэлэгдсэн үзүүлэлт гарч байна.

Гэрээний үнэлгээ бодитой эсэхэд дүгнэлт өгөх боломжгүй байна. Учир нь хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалтын байдал гэсэн хамгийн өндөр буюу 30 оноотой ерөнхий шалгуур үзүүлэлтээр төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа байгууллагын үнэлгээг аудитаар илэрсэн зөрчил, нөхцөл байдалтай уялдуулан хийхэд хангалттай үнэлгээ авах байгууллага цөөхөн байна. **/хавсралт судалгаа-**

Ийнхүү гэрээг бодитой үнэлэхгүй, урсгалаараа дүгнэж байгаа нь орон нутгийн өмчийн ашиглалт, хадгалалт, хамгаалалт сайжрахгүй, хөрөнгийн тооллого хийх үйл явц чанаргүй, тайлан мэдээ гаргалт бодитой бус, шийдвэрийн хэрэгжилт хангагдахгүй байх эх сурвалж болж байна.

Иймд өмч эзэмшүүлэх гэрээний хэрэгжилтийг бодитой дүгнэж, нотлох баримтаар баримтжуулан, архивын нэгж үүсгэн ажиллах шаардлагатай байна. Мөн гэрээний үүргээ хангалтгүй биелүүлсэн төсөв захирагч, эд хариуцагч, нягтлан бодогч нарт хариуцлага тооцон ажиллах нь зүйтэй байна.

3.5 Төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа байгууллагуудын өмч хамгаалах зөвлөлийн үйл ажиллагаа хангалтгүй байна.

Төрийн өмчит хуулийн этгээдийн өмч хамгаалах байнгын зөвлөл нь хөрөнгийн ашиглалт хамгаалалтад хяналт тавих, үр ашгийг дээшлүүлэх үндсэн үүрэгтэй байна. Байгууллагын удирдлагууд уг зөвлөлийн үйл ажиллагаанд тэр бүр ач холбогдол өгдөггүй, зөвхөн тооллогын үр дүн, хөрөнгө данс бүртгэлээс хасах асуудлыг хэлэлцэхээс бусдаар дорвитой ажил хийгээгүй байдал аудитаар ажиглагдаа.

Аймгийн ИТХ-аас баталсан журамд сумын бүх байгууллагуудын дунд нэгдсэн нэг өмч хамгаалах байнгын зөвлөлтэй байхаар зохицуулсан бөгөөд зөвлөлийн гишүүдийг судлан үзэхэд өмч хамгаалах зөвлөлийн бүрэлдэхүүнд ЗДТГ-ын алба хаагчдыг томилсон, бусад байгууллагуудын оролцоо хангалтгүй байна.

Суманд нэгдсэн нэг өмч хамгаалах зөвлөл байгуулах нь хэр оновчтой вэ гэдгийг эргэн харж журамд өөрчлөлт хийх, эсвэл өмч хамгаалах зөвлөлийн бүрэлдэхүүнд бусад байгууллагын оролцоо нэмэгдүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлж өгөх нь зүйтэй гэж үзлээ.

Аудитаар нийт 8,773.54 сая төгрөгийн зөрчил илрүүлэн 7,976.26 сая төгрөгийн зөрчилд зөвлөмж, 779.8 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага,

17.48 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 7,120.27 сая төгрөгийн санхүүгийн, 13 санхүүгийн бус үр өгөөж бүртгэлээ.

ДҮГНЭЛТ:

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйл, судалгаа, дүн шинжилгээнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

1. Аймгийн ИТХ-ын тогтоолоор баталсан холбогдох журамд эд хөрөнгө олж бэлтгэх, дансанд бүртгэх, данснаас хасах, бусдад түрээслүүлэх, хөрөнгийн ашиглалтыг хугацааг тогтоох, сунгах, хөрөнгийг дахин үнэлэх, өмч хамгаалах зөвлөлийн үйл ажиллагааны талаар нарийвчилсан зохицуулалтыг тусгаагүй байна.
2. Төрийн байгууллагуудын төсвийн хөрөнгөөр худалдан авсан тээврийн хэрэгсэл аймгийн ИТХ-ын шийдвэргүй байна.

3. Орон нутгийн хөрөнгө оруулалт, ОНХС-ийн хөрөнгийн хүрээнд бий болсон хөрөнгүүд чанаргүй, /барьсан барилга, нийлүүлсэн тээврийн хэрэгсэл, тоног төхөөрөмж/ орон нутгийн хэрэгцээ шаардлага, төрийн үйлчилгээг иргэдэд хүргэх нөхцөлийг хангахгүй, зарим хөрөнгө газрын маргаантай байна.
4. Төрийн байгууллагуудын дансанд ашиглалтад хүлээн авснаас хойш ажиллаагүй хөрөнгүүд бүртгэлтэй байна.
5. Орон нутгийн өмчид хөрөнгө бэлтгэх эх үүсвэр давхардаж, ашиглалтгүй хөрөнгүүд бий болж, хөрөнгийн илүүдэл үүссэн байна.
6. Хөрөнгө, бараа материалыг зөв ангилж бүртгээгүй, хөрөнгийн шинж чанартай зүйлсийг бараа материалын дансанд бүртгэсэн байна.
7. Үндсэн хөрөнгийн элэгдэл тооцох хугацааг бодитой тогтоогоогүй, хэт богино хугацаагаар тогтоосон байна
8. Цаашид ашиглах боломжтой хөрөнгийг дахин үнэлж, ашиглалтын хугацааг сунгахдаа элэгдэл тооцох хугацааг маш багаар тогтоосон байна
9. Хөрөнгө оруулалтаар бий болсон хөрөнгийн эзэмшигчийг тодорхойлох эрх зүйн орчин дутмаг байна.
10. Улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон хөрөнгийн ашиглалт хамгаалалт хангалтгүй байна.
11. Эд хөрөнгийг бусдад гэрээгээр эзэмшүүлж, ашиглуулах үйл явцад төсөв захирагч нар ач холбогдол өгөөгүй байна.
12. Эд хөрөнгийг бусдад ашиглуулсны /түрээсийн/ гэрээний 1 хувийг санхүүгийн алба хаагчдад өгдөггүй байна.
13. Эд хөрөнгө хариуцагчийн картын хөтлөлт хангалтгүй, гарын үсгээр баталгаажуулаагүй байна.
14. Эд хөрөнгө данснаас хасахтай холбоотой шийдвэр гаргалт хяналтгүй, учир дутагдалтай байна.
15. Улс төрийн алба хаагчдын эзэмшиж буй хөрөнгийг ажлаас чөлөөлөгдсөн тухай бүр хүлээлцдэггүй жишиг бий болсон байна.
16. Иргэд, хуулийн этгээдэд эд хөрөнгө ашиглуулахдаа холбогдох гэрээнүүдийг /түрээс, ашиглалт, хариуцлага/ хийгээгүй байна.
17. Дуудлага худалдааг нээлттэй худалдан борлуулах үйл явцын баримтжуулалт хангалтгүй, мэдээлэл авах боломжгүй байна.
18. Эд хөрөнгийн түрээсийн гэрээний шинэчилсэн заалтыг /гэрээний дүнгийн 40 хувь/ мөрдөн ажиллаагүй байна.
19. Эд хөрөнгийн түрээсийн гэрээг санхүүгийн жилээр хийгээгүй байна.
20. Эд хөрөнгийн түрээсийн төлбөрийг орон нутгийн төсөвт бүрэн төвлөрүүлээгүй, санхүүгийн жилийн эцэст тооцоо бодож, акт үйлдээгүй байна.
21. Дуудлага худалдааны орлогыг худалдах, худалдан авах гэрээний дүнтэй тулган тооцоо нийлээгүй байна.
22. Эд хөрөнгийг дуудлага худалдаа, сэлбэг хэрэгслээр борлуулсны орлогыг орон нутгийн төсөвт бүрэн төвлөрүүлээгүй байна.
23. Төрийн сан дахь орон нутгийн өмчийн орлогын данснаас дуудлага худалдаа зохион байгуулахтай холбоотой шууд зарцуулалт хийсэн байна.

24. Холбогдох эрх бүхий байгууллага, төрийн байгууллагуудын хоорондын уялдаа холбоо, мэдээлэл солилцох суваг тодорхой бус байна.
25. Эрх бүхий байгууллагуудаас гарсан шийдвэрийн хэрэгжилтэд хяналт тавьж, баримтжуулаагүй байна.
26. Эрх бүхий байгууллагуудаас хөрөнгийн ашиглалт, хамгаалалтын байдалд хяналт хэрэгжүүлээгүй, үр ашгийг дээшлүүлэх арга хэмжээ авч ажиллаагүй байна.
27. Тээврийн хэрэгсэл, машин механизмыг хадгалж хамгаалах агуулах, склад хангалтгүй байна.
28. Төсвийн ерөнхийлөн захирагч нэгдсэн тооллого зохион байгуулах үүргээ хэрэгжүүлэн ажиллаагүй байна.
29. Төсөвт байгууллагууд эд хөрөнгийн тооллогыг чанартай хийгээгүй байна
30. Төрийн өмчийг эзэмших гэрээг бодитой дүгнээгүй, гэрээний үүргээ хангалтгүй биелүүлсэн төсөв захирагч нарт хариуцлага тооцоогүй байна.
31. Байгууллагын удирдлагууд өмч хамгаалах зөвлөлийн үйл ажиллагаанд ач холбогдол өгөхгүй байна.
32. Сумын төсөвт байгууллагуудын дунд нэг өмч хамгаалах зөвлөл томилсон байна.

ЗӨВЛӨМЖ:

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дор дурдсан албан тушаалтанд зөвлөж байна.

Аймгийн ИТХ-ын даргад:

1. Аймгийн ИТХ-ын тогтоолоор 2018 оны 25 дугаар тогтоолоор баталж, Аймгийн ИТХ-ын VIII хуралдааны 49 дүгээр тогтоолоор шинэчлэн баталсан “Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн харилцааг зохицуулах журам”-ыг шинэчлэн найруулж, нарийвчилсан зохицуулалтуудыг тусгах, Ингэхдээ

- хүчингүй болгосон заалтуудыг эргэн харж, журамд тусгах, төсөв захирагч, санхүүгийн алба хаагчдаас санал авахад анхаарах;
2. Аймгийн ИТХ-аар баталсан журмын хавсралтаар хөрөнгийн ашиглалтын хугацааг хэрхэн тогтоох талаар тодорхой тусгаж, баталж өгөх;
 3. Аймгийн ИТХ-ын хуралдааны 2019 оны 51 дүгээр тогтоолоор баталсан “орон нутгийн өмчийн эд хөрөнгө, түрээслүүлэх журам”-д түрээсийн гэрээний үнийн дүнгийн 40 хувийг орон нутагт төсөвт төвлөрүүлэх шинэчлэл хийх;
 4. Орон нутгийн өмчийн газрыг үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэхэд шаардлагатай санхүүгийн нөөцөөр хангаж, бодлогын шинж чанартай арга хэмжээ авч ажиллах;
 5. Орон нутгийн байгууллагын төсөв захирагч, санхүүгийн алба хаагч нарт эрх зүйн зохицуулалтын талаар сургалт хийх ажлыг зохион байгуулах;
 6. Тухайн байгууллагын бэлтгэх хөрөнгө нь хэрэгцээ шаардлагад нийцэж буй талаар хэлэлцэн, зөвшөөрөл олгож байх;
 7. Тээврийн хэрэгслийг данс бүртгэлээс хасах шийдвэр гаргахдаа дуудлага худалдаагаар худалдан борлуулах, сэлбэг хэрэгслээр худалдах гэсэн шат дараалсан арга хэмжээ авч байх;
 8. Аймгийн ИТХ-ын даргын захирамж, тэргүүлэгчдийн тогтоолоор гарсан шийдвэрийн хэрэгжилтэд хяналт тавьж, хэрэгжилт нь хангагдаагүй шийдвэрүүдийн биелэлтийг хангуулан, баримтжуулан ажиллах;
 9. Сумдын ИТХ-аас гаргаж буй эд хөрөнгөтэй холбоотой шийдвэрт хяналт тавьж, арга зүйн зөвлөгөө өгч байх;

Сумын ИТХ-д:

1. Орон нутгийн өмчид хөрөнгө олж бэлтгэх, хөрөнгө данс бүртгэлээс хасах шийдвэр гаргахдаа үр дагавар, нөхцөл байдлыг бодитой үнэлж байх;
2. Хөрөнгийг дахин үнэлж, ашиглалтын хугацааг сунгах саналыг эрх бүхий байгууллагад хүргүүлэхдээ элэгдэл тооцох хугацааг бодитой тогтоосон эсэхийг хянах;
3. Төсөвт байгууллагуудын хөрөнгийг, ялангуяа тээврийн хэрэгсэл, техник, машин механизмыг нэг дор байршуулан, ашиглалтад хяналт тавих боломжоор хангах арга хэмжээ авч ажиллах;

Аймгийн Засаг дарга буюу төсвийн ерөнхийлөн захирагчид:

1. Улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт, аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр бий болсон хөрөнгийг данс бүртгэлд тусгах тухай шийдвэрийг тогтмол гаргаж, хэрэгжилтэд хяналт тавьж байх;
2. Илүүдэлтэй мотоцикл, тээврийн хэрэгслийг тухайн хөрөнгө дутагдалтай байгууллагуудад шилжүүлэх арга хэмжээ авч, хөрөнгийн ашиглалт, хамгаалалтыг сайжруулах;
3. Төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа байгууллагуудын дансанд бүртгэлтэй илүүдэлтэй болон ашиглалтгүй хөрөнгийн үнэ цэнэ буурч, эвдэрч гэмтэхээс өмнө дуудлага худалдаагаар худалдан борлуулах;

4. Улсын төсвийн хөрөнгө оруулалтын хүрээнд бий болсон ашиглалт нь тодорхойгүй, ашиглах боломжгүй хөрөнгүүдийг буцаах /хог шатаах зуух/, хэрэгцээтэй газарт балансаас шилжүүлэх, ашиглалтыг сайжруулах арга хэмжээ авч ажиллах;
5. Улс төрийн алба хаагчдад ажлаас чөлөөлөгдсөн нөхцөлд олгодог нэг удаагийн тэтгэмжийг тухайн байгууллагын дансаар дамжуулан олгох;
6. Эрх бүхий байгууллагуудын хөрөнгийн ашиглалтад тавих хяналтыг сайжруулж арга хэмжээ авч ажиллах;
7. ТЕЗ харьяа байгууллагуудын хөрөнгийн эд хөрөнгийн нэгдсэн тооллогыг чанартай хийж, үр дүнг аймгийн ИТХ-аар хэлэлцүүлэн, алдаа дутагдлыг засаж залруулах арга хэмжээ авч хэвших;
8. Төрийн өмчийг эзэмшүүлэх гэрээний үүргээ хангалтгүй биелүүлсэн алба хаагчдад хариуцлага тооцож байх;
9. Аудитаар байгууллагын дарга, нягтлан бодогч нарт өгсөн шийдвэрийн хэрэгжилтийг хангуулах ажлыг зохион байгуулж, хэрэгжилтийг ханган ажиллаагүй төсөв захирагч нарт хариуцлага тооцон ажиллах;
10. ТЕЗ-с сумдын төсөв захирагч нарт төрийн өмчийг бусдад хэрхэн ашиглуулах талаар чиглэл өгч, арга зүйгээр ханган ажиллах ;

Орон нутгийн өмчийн газарт:

1. Төрийн байгууллагуудын жилийн эцсийн тайлан нэгтгэхдээ хөрөнгө, бараа материалын хөдөлгөөн, элэгдэл тооцох хугацааг бодитой тодорхойлсон эсэхэд хяналт тавьж, алдаа зөрчлийг тухай бүр залруулан ажиллах;
2. Дуудлага худалдаагаар тухайн байгууллагын хөрөнгө зарагдсан нөхцөлд худалдах, худалдан авах гэрээ, төлбөр төлсөн баримтыг эзэмшигч байгууллагад хүргүүлж, хэрэгжилтэд хяналт тавьж байх;
3. Төсөвт байгууллагуудын эд хариуцагч, нярав нарт сургалт хийж, арга зүйгээр хангаж ажиллах ;
4. Төрийн өмчийг бусдад ашиглуулахад ямар нөхцөлд, ямар төрлийн гэрээ хийж баримтжуулж байх талаар төсөв захирагч нарт чиглэл өгч, арга зүйгээр ханган ажиллах, холбогдох гэрээ, маягтын загварыг бэлтгэж мөрдүүлэх;
5. Аудитаар илэрсэн бодитоор байхгүй, ашиглах боломжтой эсэх нь тодорхойгүй хэнд, хэзээ эзэмшүүлсэн нь тодорхой бус хөрөнгүүдийг данснаас хасах шийдвэр гаргахдаа бодитой хандаж, хяналт тавьж ажиллах;
6. Тухайн хөрөнгө нээлттэй дуудлага худалдаагаар зарагдаагүй байхад данс бүртгэлээс хассан асуудлыг судлан үзэж, төрийг хохиролгүй болгох;
7. Их-Уул сумын дансанд бүртгэгдээгүй тээврийн хэрэгслийн зөрчлийг арилгаж, холбогдох арга хэмжээ авч ажиллах;
8. Байгууллагын дансанд бүртгэлтэй орон сууцыг иргэнд шагнал болгон өгсөн асуудлыг судлан, холбогдох арга хэмжээг авч ажиллах;
9. Эд хөрөнгийг нээлттэй дуудлага худалдаагаар худалдах, төрийн өмчийн гэрээ дүгнэсэн баримт, түрээсийн гэрээ зэрэгтэй холбоотой архивын баримтын эмх цэгцийг ханган ажиллах;

10. 2026 онд байгуулах түрээсийн гэрээний нөхцөлд өөрчлөлт оруулан үнийн дүнгийн 40 хувийг орон нутгийн төсөвт төвлөрүүлэх;
11. Эд хөрөнгийн түрээсийн гэрээг санхүүгийн жилээр байгуулан гэрээний хэрэгжилтийг хангуулж, түрээсийн орлогыг санхүүгийн жилд багтаан орон нутгийн төсөвт төвлөрүүлж байх;
12. Сэлбэг хэрэгслээр худалдан борлуулсан хөрөнгийн болон хууль хяналтын байгууллагаас тогтоосон нөхөн төлбөрийн орлогыг орон нутгийн өмчийн орлогын дансанд төвлөрүүлэх;
13. Төрийн өмчийг эзэмшүүлэх гэрээг бодитой, шударга дүгнэж, үр дүнг аймгийн засаг даргад танилцуулж, гэрээний үүргээ хангалтгүй биелүүлсэн алба хаагчдад хариуцлага тооцуулах саналыг хүргүүлж байх;

Байгууллагын дарга, нягтлан бодогч нарт:

1. Үндсэн хөрөнгийг буруу ангилж бүртгэснийг холбогдох дансанд шилжүүлэн залруулах;
2. Бараа материалын дансанд бүртгэсэн хөрөнгийн шинжтэй зүйлсийг холбогдох хөрөнгийн дансанд шилжүүлэн бүртгэж, бараа материалын үлдэгдлийг цэгцлэх;
3. Төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулж, хэрэгцээгүй хөрөнгө бэлтгэж, материалын нөөц бүрдүүлэхгүй байх
4. Зураг төслийг санхүүгийн тайланд авлагаар бүртгэн тухайн төсөл хөтөлбөр хэрэгжих үед нь суутган тооцож байх;
5. Үндсэн хөрөнгө, бараа материалд болон бусад байгууллагуудтай давхар бүртгэсэн хөрөнгийг залруулах;
6. Байгууллагын үйл ажиллагаандаа мөрдөж буй санхүүгийн программд эд хөрөнгийг кодолж, хөрөнгө, материалын нэрийг ойлгомжтой хэлбэрээр оруулж засах;
7. Ашиглалтын хугацааг огт оруулаагүй болон цөөхөн жилээр оруулсан хөрөнгүүдийн хугацааг засаж оруулах;
8. Дансанд тусгаагүй мөртөө ашиглаж буй хөрөнгүүдийг бүртгэлд тусган, эд хөрөнгө хариуцагчийн картаар алба хаагчдад эзэмшүүлэх;
9. Элэгдлээрээ өртгөө нөхсөн хөрөнгүүдийг цаашид ашиглах боломжтой эсэхийг тодорхойлж, дахин үнэлж, ашиглалтын хугацааг сунган ажиллах;
10. Байгууллагын дансанд бүртгэлтэй хөрөнгө, бараа материалыг алба хаагчдад эзэмшүүлж, эд хөрөнгө хариуцагчийн картыг иж бүрэн хөтөлж, алба хаагчдаар гарын үсэг зуруулан баталгаажуулах;
11. Эд хөрөнгө хариуцагчийн картыг тухайн эд хариуцагчийн хөрөнгөнд хөдөлгөөн орсон тухай бүр шинэчлэн хөтөлж хэвших;
12. Эрх бүхий байгууллагын шийдвэр гараагүй нөхцөлд хөрөнгийг дур мэдэн бусдад шилжүүлэхгүй байх;
13. Эрх бүхий байгууллагаас гарсан эд хөрөнгөтэй холбоотой шийдвэрийн хэрэгжилтийг тухай бүр ханган ажиллах;
14. Бараа материал дансанд бүртгэсэн хөрөнгийн шинж чанартай зүйлсийг эрх бүхий байгууллагын шийдвэрт үндэслэн акталж, данс бүртгэлээс хасах

15. Дуудлага худалдаагаар зарагдсан эсэх нь тодорхой бус, дансанд бүртгэлтэй хөрөнгийг холбогдох газарт уламжлан шийдвэрлүүлэх
16. Төрийн алба хаагч болон улс төрийн алба хаагчид ажлаас чөлөөлөгдсөн тохиолдолд тойрох хуудсаар ажлыг хүлээлцэн, тооцоо бодож, эзэмшиж байсан байгууллагын дансанд бүртгэлтэй хөрөнгийг буцаан авсны дараа тэтгэмжийг олгодог байх;
17. Эрх бүхий байгууллагад хүргүүлэн данс бүртгэлээс хасах саналд тусгагдсан хөрөнгүүдийг бодитоор, байгууллагын байршилд татан авч, холбогдох өмч хамгаалах зөвлөлийн гишүүдэд нүд үзүүлэн дүгнэлт гаргуулж байх;
18. Эд хөрөнгийн толлогыг чанартай, нүд үзэн хийж, тооллогын үр дүнг өмч хамгаалах зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн, холбогдох шийдвэрүүдийг тухай бүр гаргуулж байх;
19. Байгууллагын дансанд бүртгэлтэй хөрөнгийг бусдад түр ашиглуулахдаа эд хариуцагчид мэдэгдэж, хүлээлгэн өгсөн, авсан талаар баримт үйлдэж, тухайн хөрөнгийн ашиглалтад хяналт тавьж, хөрөнгөнд эвдрэл гэмтэл үүсэн нөхцөлд буруутай этгээдээр төлүүлж улсыг хохиролгүй болгож байх
20. Байгууллагын дансанд бүртгэлтэй эд хөрөнгийг бусдад ашиглуулсан /түрээслүүлсэн/ нөхцөлд хийсэн гэрээний 1 хувийг санхүүгийн алба хаагчид өгч, гэрээний хэрэгжилтийг хангуулах, тооцоо бодох нөхцөлийг бүрдүүлж өгөх;

Зөвлөмжийн мөрөөр хийх ажлын төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д “Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ” гэж заасан хугацаанд, зөвлөмжийг биелэлтийг 2026 оны 07 дугаар сарын 05-ны дотор ирүүлэх

АЛБАН ШААРДЛАГА:

Аймгийн засаг даргад:

1. Байгууллагын дансанд бүртгэлтэй барилга байгууламжийн газрын бүртгэлд нэгдсэн хяналт хэрэгжүүлэн, данс бүртгэлд тусгах, маргаантай асуудлыг шийдвэрлэх арга хэмжээ авч ажиллах:

Орон нутгийн өмчийн газарт:

1. Байгууллагын дансанд бүртгэлтэй тээврийн хэрэгслийг гэрчилгээжүүлж, цэнхэр дугаар авах ажлыг төсөв захирагч нартай хамтран зохион байгуулах;

2. Түрээсийн төлбөрийн дутуу болон хуулийн байгууллагад шилжүүлсэн асуудлын хэрэгжилтийг хангуулан, орон нутгийн төсвийн дансанд төвлөрүүлэх;
3. Дуудлага худалдааны орлогын төлөгдөөгүй үлдэгдлийг буруутай этгээдээр төлүүлэн, төсөвт дансанд төвлөрүүлэх;

Байгууллагын дарга, нягтлан бодогч нарт

1. Ашиглалтад хүлээн авснаас хойш одоог хүртэл ажиллаагүй болон газрын маргаантай хөрөнгүүдийг хууль хяналтын байгууллагад шилжүүлэн буруутай этгээдээр хохирлыг нөхөн төлүүлэх;
2. Шийдвэр давхардуулан гаргасны улмаас үр дагавар бий болсон тээврийн хэрэгслийг хуулийн байгууллагад шилжүүлж, буруутай этгээдээр нөхөн төлүүлэх;
3. Хууль хяналтын байгууллагад шалгагдаж буй хөрөнгийн хэрэгжилтийг хангуулан, хуулийн байгууллагатай хамтран ажиллаж, буруутай этгээдээр нөхөн төлүүлэх;
4. Аудитын тооллогоор дутагдсан тээврийн хэрэгсэл, бага оврын дизель станцыг хуулийн байгууллагад шилжүүлэн, буруутай этгээдээр нөхөн төлүүлэх;
5. Аудитаар илэрсэн бодитоор байхгүй, ашиглах боломжтой эсэх нь тодорхойгүй, хэнд, хэзээ эзэмшүүлсэн нь тодорхой бус хөрөнгүүдийн эзэн холбогдогчийг тодорхойлж, холбогдох арга хэмжээ авч ажиллах;
6. Төрийн өмчид бүртгэлтэй хөрөнгийг бусдад түрээслүүлсэн гэрээний хэрэгжилтийг хангуулан ажиллах;
7. Тоногдсон хөрөнгийг хууль хяналтын байгууллагад шилжүүлэн, буруутай этгээдээр нөхөн төлүүлж, төрийг хохиролгүй болгох;

ТӨЛБӨРИЙН АКТ:

Байгууллагын дарга, нягтлан бодогч нарт:

1. Аудитын тооллогоор дутагдсан, анхнаасаа нийлүүлэгдээгүй хөрөнгийг данс бүртгэлд тусгасан зэрэгтэй холбоотой 17.98 сая төгрөгийн зөрчилд

Байгууллагын санал:

Аудитын тайланг аймгийн ТЕЗ, Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Орон нутгийн өмчийн газарт хүргүүлэн холбогдох саналыг авсан болон. Аймгийн ТЕЗ-аас аудитын тайлантай холбоотой санал ирүүлээгүй бөгөөд бусад байгууллагаас ирүүлсэн саналыг дараах байдлаар шийдвэрлэлээ.



МОНГОЛ УЛС
ЗАВХАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА

Хатанбаатар Магсаржавын 1-116 тоот
Улиастай сум, Завхан аймаг 81090
Утас: 7575-1155, Факс: 7046-2550
Цахим шуудан: info@zavkhan.gov.mn
Цахим хуудас: Zavkhan.gov.mn

2025. 12. 04 № 01/1155
танай _____-ны № _____ Т

ЗАВХАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗАРТ

Төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа
байгууллагуудын "хөрөнгийн ашиглалт,
хамгаалалт" сэдэвт гүйцэтгэлийн аудитын
тайлангийн төсөлтэй танилцлаа.

ЗАСАГ ДАРГА  Т.ӨНӨРБАЯР



8125110392 Төрийн 2022



ЗАВХАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН
ГАЗАРТ

Санал хүргүүлэх тухай

Завхан аймаг дахь Төрийн аудитын газрын байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хүрээнд хийсэн "Төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа байгууллагуудын хөрөнгийн ашиглалт хамгаалалт" сэдэвт гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцаад дараах саналыг хүргүүлж байна.

Гүйцэтгэлийн тайлангийн 32 дугаар хуудасны аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өгч байгаа зөвлөмжөөс Орон нутгийн өмчийн газрыг үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэхэд шаардлагатай хүний нөөц, болон санхүүгээр хангаж ажиллах чиг үүргийг хасуулах саналтай байна.

Учир нь Завхан аймаг дахь Төрийн аудитын газраас өгсөн саналыг үндэслэн Орон нутгийн өмчийн газрын орон тоог Сангийн яамнаас батлагдсан төсөвт багтааж ажиллуулах талаар хасах чиглэл өгсний дагуу орон тоог бууруулж баталсан байх тул хүний нөөцийг нэмэгдүүлэх боломжгүй гэж үзэж байна.

Орон нутгийн байгууллагын төсөв захирагч, санхүүгийн алба хаагч нарт эрх зүйн зохицуулалтын талаар сургалт зохион байгуулах ажлыг чиг үүрэгт хамгийн ойр байх албан тушаалтанд хариуцуулах нь оновчтой байх тул хасуулах саналтай байна.

ДАРГА ШИМЯНГАНБАЯР

8109012185

Аймгийн ИТХ-аас ирүүлсэн саналыг шийдвэрлэсэн байдал:

д/д	Ирүүлсэн санал	Шийдвэрлэсэн байдал
1	Аймгийн ИТХ-д өгөх зөвлөмжид тусгасан "Орон нутгийн өмчийн газрыг үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэхэд шаардлагатай хүний нөөц, санхүүгээр хангаж ажиллах" гэсэн заалтыг хасуулах	Аудитаар илэрсэн алдаа зөрчлийн нөхцөл байдлыг харахад гэмт хэргийн шинж чанартай /хулгайлах, тонох, эрх бүхий байгууллагын шийдвэргүй данс бүртгэлээс хасах, ашиглалтын хугацааг цөөхөн жилээр тооцон бусдад давуу байдал олгох гэх мэт/ зүйлс ажиглагдсан. Иймд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардлаас орон нутгийн эд хөрөнгийн ашиглалт, хамгаалалтад зарцуулж, болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч ажиллах нь зүйтэй гэж үзсэн тул уг зөвлөмжийн утга найруулгыг сайжруулан хэвээр үлдээлээ.
2	"Орон нутгийн байгууллагуудын төсөв захирагч, санхүүгийн алба хаагч нарт эрх зүйн зохицуулалтын талаар сургалт зохион байгуулах" гэсэн зөвлөмжийг хасуулах	Аймгийн ИТХ нь орон нутгийн өмчийн эзэмшигчийн хувьд хөрөнгийн ашиглалт хамгаалалтыг сайжруулах, үр ашгийг дээшлүүлэх зорилгоор холбогдох алба хаагчдад зориулсан сургалтын зохион байгуулалтыг хариуцан, мэргэжлийн байгууллагаар сургалтыг хийлгүүлэх боломжтой гэж үзсэн тул зөвлөмжийн утга найруулгыг сайжруулан хэвээр үлдээлээ.



**ЗАВХАН АЙМГИЙН
ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ГАЗАР**

Улиастай сум, Завхан аймаг 81090

Утас: 77002802

Цахим шуудан: info@umch.za.gov.mn

Цахим хуудас: umch.za.gov.mn

2025.12.03 № 2025
танай 2025.11.28 -ны № 719 Т

**ЗАВХАН АЙМГИЙН
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ**

“Төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа
байгууллагуудын хөрөнгийн ашиглалт
хамгаалалтад гүйцэтгэлийн аудит хийсэн тайлан”-
ийн төсөлтэй танилцан санал, тайлбараа хүргүүлж
байна.

Хувийг: Аймгийн Засаг даргад

Хавсралт 14 хуудастай.

ДАРГА  Д. БАТМЭНД



.. 810905305

Орон нутгийн өмчийн газраас ирсэн саналыг шийдвэрлэсэн байдал:

д/д	Ирүүлсэн санал	Шийдвэрлэсэн байдал
1	Ашиглалтад хүлээн авснаас хойш одоог хүртэл ажиллаагүй болон газрын маргаантай хөрөнгүүдийг хууль хяналтын байгууллагад шилжүүлэн буруутай этгээдээр хохирлыг нөхөн төлүүлэх гэсэн албан шаардлагыг тухайн байгууллагууд руу өгөх	Саналыг хүлээн авч тухайн байгууллагуудад өгөхөөр шийдвэрлэлээ.
2	Их-Уул сумын дансанд бүртгэгдээгүй тээврийн хэрэгслийн зөрчлийг арилгаж, холбогдох арга хэмжээ авч ажиллах гэсэн албан шаардлагыг зөвлөмжөөр авах. Тухайн хөрөнгө нь улсын онцгой комиссын тогтоолтой. Энэ асуудал манай байгууллагад мэдэгдэхгүйгээр шийдэгдсэн бөгөөд асуудлыг шийдвэрлэхээр ажилласан боловч хэрэгжилт хангалтгүй байна.	Саналыг хүлээн авч зөвлөмжөөр өгөхөөр шийдвэрлээ.
3	Шийдвэр давхардуулан гаргасны улмаас үр дагавар бий болсон тээврийн хэрэгслийг хуулийн байгууллагад шилжүүлж, буруутай этгээдээр нөхөн төлүүлэх гэсэн албан шаардлагыг тухайн байгууллагад нь хүргүүлэх.	Саналыг хүлээн авч тухайн байгууллагуудад өгөхөөр шийдвэрлэлээ.
4	Дуудлага худалдаагаар тухайн байгууллагын хөрөнгө зарагдсан нөхцөлд худалдах, худалдан авах гэрээ, төлбөр төлсөн баримтыг эзэмшигч байгууллагад хүргүүлж, хэрэгжилтэд хяналт тавьж байх талаар албан тоотоор хүргүүлэн ажилладаг тул зөвлөмжөөс хасаж өгнө үү	Албан тоотоор хүргүүлдэг хэдий ч хэрэгжилтэд хяналт тавьж, баримтжуулаагүй байгаа тул зөвлөмжийг хэвээр үлдээлээ.
5	Аудитаар илэрсэн бодитоор байхгүй, ашиглах боломжтой эсэх нь тодорхойгүй хэнд, хэзээ эзэмшүүлсэн нь тодорхой бус хөрөнгүүдийг данснаас хасах шийдвэр гаргахдаа бодитой хандаж, хяналт тавьж ажиллах гэсэн зөвлөмжийн хүрээнд аймгийн төвийн байгууллагуудын хөрөнгийг нүд үзэн шийдвэр гаргадаг, харин сумдад ажиллахад санхүүгийн асуудал хүндрэлтэй байдаг тул хэрэгжүүлэхэд хүндрэлтэй байна.	Санхүүгийн асуудлыг шийдвэрлэх талаах аймгийн ИТХ-д зөвлөмж хүргүүлсэн тул уг зөвлөмжийг хэвээр үлдээхээр шийдвэрлээ.
6	Хууль хяналтын байгууллагад шалгагдаж буй хөрөнгийн хэрэгжилтийг хангуулан, хуулийн байгууллагатай хамтран ажиллаж, буруутай этгээдээр нөхөн төлүүлэх гэсэн албан шаардлагыг тухайн байгууллагад хүргүүлэх	Саналыг хүлээн авч тухайн байгууллагуудад өгөхөөр шийдвэрлэлээ.
7	Аудитын тооллогоор дутагдсан тээврийн хэрэгсэл, бага оврын дизель станцыг хуулийн байгууллагад шилжүүлэн, буруутай этгээдээр нөхөн төлүүлэх албан шаардлагыг тухайн байгууллагад хүргүүлэх	Саналыг хүлээн авч тухайн байгууллагуудад өгөхөөр шийдвэрлэлээ.
8	Байгууллагын дансанд бүртгэлтэй орон сууцыг иргэнд шагнал болгон өгсөн асуудлыг судлан, холбогдох арга хэмжээг авч ажиллах албан шаардлагыг зөвлөмж болгуулах. Уг байранд амьдарч байгаа иргэнийг байрнаас гаргах, эсвэл ашиглалтын гэрээ байгуулахыг зөвлөж байна.	Саналыг хүлээн авч зөвлөмжөөр өгөхөөр шийдвэрлээ.
9	Түрээсийн орлого нь орон нутгийн төсвийн дансанд төвлөрдөг тул албан шаардлага болгож өгнө үү. 2024 оны жилийн эцсийн байдлаар 6,900.0 мянган төгрөгийн	Орон нутгийн эд хөрөнгө түрээслүүлсний орлогыг орон нутгийн өмчийн дансанд бүрэн

ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧИЙН ХАРЬЯА БАЙГУУЛЛАГУУДЫН ХӨРӨНГИЙН АШИГЛАЛТ, ХАМГААЛАЛТ

	түрээсийн орлого төвлөрүүлээгүйгээс 5,679.0 мянган төгрөгийн төлбөрийг хуулийн байгууллагад шилжүүлсэн, 1,221.0 сая төгрөгийн орлогыг төвлөрүүлээгүй, 2025 онд төвлөрүүлэхээр тохиролцсон.	төвлөрүүлэх албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэлээ.
10	Түрээсийн талбайн м2-ын хэмжээг Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газраас тогтоосон доод хязгаартай уялдуулан эрх бүхий байгууллагаар тогтоолгон, хэрэгжилтийг ханган ажиллах гэсэн зөвлөмжийн хүрээнд Завхан аймгийн ИТХ-ын 2019 оны 12-р сарын 02-ны өдрийн 51 дүгээр тогтоолоор "Орон нутгийн өмчийг түрээслүүлэх журам"-ын 5.1- 5.5 хэсгийн баримталж байна.	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2020 оны 49 дүгээр тогтоолоор "Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийн түрээсийн төлбөрийн доод хязгаар, түрээсийн зарим төлбөрийн хэмжээг тогтоох заавар", тус оны 50 дугаар тогтоолоор "Төрийн өмчийн эд хөрөнгийн түрээсийн талаар авах зарим арга хэмжээний тухай" тогтоолоор төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийн түрээсийн гэрээний үлгэрчилсэн загварыг баталсан байхад тухайн журамд өөрчлөлтийг хийгээгүй байна. Иймд тухайн аймгийн ИТХ-ын хуралдааны тогтоолд өөрчлөлт оруулах зөвлөмжийг Аймгийн ИТХ-д хүргүүлэхээр шийдвэрлэлээ.
11	2026 онд байгуулах түрээсийн гэрээний нөхцөлд өөрчлөлт оруулан үнийн дүнгийн 40 хувийг орон нутгийн төсөвт төвлөрүүлэх зөвлөмжийн хүрээнд Аймгийн ИТХ-ын хуралдааны 2019 оны 51 дүгээр тогтоолоор баталсан өөрчлөлт хийгээгүй тул 30 хувийг төвлөрүүлж байна.	Аймгийн ИТХ-д тус журамд өөрчлөлт оруулах зөвлөмж хүргүүлсэн тул зөвлөмжийг хэвээр үлдээлээ.
12	Орон нутгийн өмчийг худалдан борлуулсны орлогыг орон нутгийн төсөвт төвлөрүүлдэг тул албан шаардлага болгож өгнө үү. Баримтад дахин тулгалт хийж нотлох баримтыг хүргүүллээ.	Ирүүлсэн баримтаар тулгалт хийхэд 4,450.0 мянган төгрөгийн төлбөр төлөгдөөгүйд төрийн сан дахь орон нутгийн өмчийн дансанд төвлөрүүлэх албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэлээ.

ЗАВХАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР